

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

ЭМ ЗҮЙН СУРГУУЛЬ

ЭМ ЗҮЙ D091601

БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР ХОТ 2017 ОН

Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал:

1. Мэргэжилтний эрэлт хэрэгцээ өндөр эдүгээ улсын хэмжээнд наад зах нь 5998 мэргэжилтэн хэрэгцээтэйг тооцож тогтоосон
2. Эм зүйн Шинжлэх ухаан хурдацтай хөгжиж эрэлт хэрэгцээ ихсэж байгаа мэргэжилтний чадвар чансаанд тавигдах шаардлага өндөр болж байгаа нь сургалтын чанарыг эрс сайжруулах нийгмийн хэрэгцээг илэрхийлж байна хэмээн дүгнэж сургалтын бодлогод өөрчлөлт хийжээ:
 - а. Сургалтын SPICES загвараар: **Оюутан төвтэй, асуудалд суурилсан, нийгэмд тулгуурласан, мэдлэгийг дэс дараатай эзэмшүүлэх** зарчим баримтлан **багаар ажиллах чадвартай** мэргэжилтэн бэлдэж байгаа.
3. Эм зүйчийн хэрэгцээ жилээс жилд өсч байна:
 - (a) 1 эм зүйчид ногдох үйлчлүүлэгч - 2016,9 хүн
 - (b) 10000 –н хүнд хотод 6,48 ба хөдөөд 2,86 эм зүйч ногдож байгаа
 - (c) Улсын хэмжээнд эмийн мэргэжилтэн ажиллах байгуулгын тоо эрс өссөн: эм ханган нийлүүлэх байгуулга – 170 шахам (8-10 эм зүйч), Эмийн үйлдвэр – 32 (12-14 эм зүйч), Эмийн сан – 1496 (4-5 эм зүйч), нийт 5500 орчим эмийн мэргэжилтэн шаардлагатай байна

1. Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар

1. Төрөөс баримтлаж байгаа бодлогод нийцүүлэн **„Эм зүйн ухааны бакалаврын боловсролыг эзэмшиж, эм барих зөвшөөрөл авсан, эмийн бодисын үйлдлийн механизм, хэрэглэх заалт, гаж нөлөө зэрэг эмнэлзүйн суурь мэдлэгтэй, эм үйлдвэрлэх технологийг эзэмшсэн, эмийн чанарын баталгаажуулалт, сорилт шинжилгээ хийх болон хүн амд эм зүйн тусламж, үйлчилгээг ёс зүй, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх чадвартай, онол арга зүйн, эрдэм шинжилгээний судалгааны ажлын мэдлэгтэй мэргэжилтэн байна“** хэмээн мэргэжилтний загварыг тодорхойлсон байна.
2. Эм зүйн мэргэжлийн чиглэлийн зориулалтыг **„Эм зүйч нь эмнэл-зүйд суурилсан эм зүйн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллага, хүн амыг эм, эмнэлэгийн хэрэгсэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүнээр хангахад чиглэсэн бүх талын харилцааг зохицуулах мэдлэг, чадвар, хандлага эзэмшиж, эм зүйн байгууллагад ерөнхий мэргэжилтэн, клиникийн эмнэлгүүдэд клиникийн эм зүйчээр ажиллана“** гэж заасан байна.

3. Дээрх загварт нийцсэн мэргэжилтэн бэлтгэхийн тулд Эм зүйч бэлтгэх хөтөлбөр хийгээд сургалтын агуулга ба хэрэгжүүлэх бүхийл үйл ажиллагааг “**Эмийн хангамжид чиглэсэн тусламж үйлчилгээнээс - Үйлчлүүлэгч рүү чиглэсэн, Эмнэл зүйн, эмзүйн тусламж үйлчилгээ**” гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх зарчимд нийцүүлэн өөрчилсөн нь үнэлэж сайшаах ахиц дэвшил мөн.

2. Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

1. АШУҮИС-ын Эм зүйн сургуулийн Эм зүйч бэлтгэх одоогийн магадлан итгэмжлэлд орж байгаа хөтөлбөр нь эмнэл зүйн хичээлийн агуулгыг өргөтгөн 2015 онд шинэчлэн батласан хубилбар ажээ.

2. АШУҮИС-ийн эм зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг гадаадын Япон, Турк, Австрали, АНУ-ын их, дээд сургуулиудын эм зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөртэй харьцуулан ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийн эзлэх хувь, агуулгыг харьцуулж Зураг 1-ээр харуулан Туркийнхээс мэргэжлийн суурь хичээлийн агуулга нь арай бага харин Японы Хоккайдо, АНУ ба Австралийн ЭЗС-тай бараг ижил харьцаатай байна гэсэн дүгнэлт хийжээ.

3. Дотоодын их, дээд сургуулиудын Эм зүйч мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөртэй харьцуулсан дүн

i) Сургалтын төлөвлөгөөг 9 удаа өөрчилсөн хамгийн хожим 2015 онд эм зүйн сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн суурь хичээлүүдийг түлхүү нэмж багц цагийн хувьд 2005 онд 164 байсан бол 2015 онд 173 багц цаг болгон шинэчлэгдэн эмнэл-зүйн хичээлүүдийг түлхүү тусгасан хөтөлбөр болсон. Монгол улсын хэмжээнд эм зүйч мэргэжилтэн бэлтгэж байгаа дотоодын их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн агуулгыг харьцуулан авч үзсэн үр дүнг өөрийн үнэлгээний тайлангийн 9-10-р хуудсанд Зураг 1,2 ба 1,3-р харуулжээ.

ii) АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрт ерөнхий суурь хичээл 52 багц цаг буюу 30%, мэргэжлийн суурь хичээл 44 багц цаг буюу 25% болон мэргэшүүлэх хичээл 77 багц цаг буюу нийт хичээлийн 45%-ийг эзэлж байна.

iii) Харин Монос Анагаах ухааны дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ерөнхий суурь хичээл 47 багц цаг буюу 26,3%, мэргэжлийн суурь хичээл 40 багц цаг буюу 22,3% болон мэргэшүүлэх хичээл 92 багц цаг буюу 51,4%,

iv) Этүгэн дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ерөнхий суурь хичээл 46 багц цаг буюу 29,3%, мэргэжлийн суурь хичээл 39 багц цаг буюу 24,8% болон мэргэшүүлэх хичээл 72 багц цаг буюу 45,9% тус тус эзлэж байна.

v) Дотоодын их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр дэх хичээлүүдийн харьцуулалтыг Эм зүйн албаны зохион байгуулалт, эмийн технологи, эмийн хими, болон эмнэл-зүйн эмзүй гэсэн дөрвөн чиглэлийн мэргэшүүлэх хичээлээр харьцуулан авч үзээд АШУҮИС-ийн ЭЗС-ийн эмнэлзүйн эм зүйн хичээлүүд нь нийт хичээлийн 28% буюу хамгийн их багц цагтай, Монос ба Этүгэн их сургуулийн -ийн эмнэлзүйн эм зүйн хичээл нь 12% буюу хамгийн бага бөгөөд 16 хувиар дутуу агуулгатай байгааг тогтоогоод өөрийн хөтөлбөрийн давуу талыг тэмдэглэн шийдвэртэй хэрэгжүүлж байгаа ажээ.

Дүгнэлт: АШУҮИС-ийн “Эм зүйч” хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг харгалзсан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг судласан мэдээлэлд тулгуурлан боловсруулж Монгол улсын стандарт, эрүүл мэндийн салбарын эм зүйч мэргэжилтэний мэргэжлийн загвар тодорхойлсон баримт зэрэгт нийцүүлэн нийгмийн хэрэгцээ хангахад чиглүүлэн сайжруулж 2015 онд боловсруулагдан хэрэгжиж байгааг харуулсан үйл ажиллагааны илэрхийлэл, нотолгооны иж бүрдэл бүхий баримт бичиг юм байна.

АШУУИС-ийн “Эм зүйч” хөтөлбөрийн төлөвлөлт нь 2011 онд хийгдсэн Магадлан итгэмжлэлээс гарсан зөвлөмжийн зүйл заалтуудыг хэрэгжүүлж, өөрийн үнэлгээний SWOT шинжилгээнд ахиц дэвшил гаргаж чадсанаа харуулсан БМИУЗ-ийн тавьж байгаа шаардлагыг биелүүлсэн байна.

Зөвлөмж:

- 1) Сургууль, сургалтын бүхийл үйл ажиллагааг нарийн төлөвлөж төлөвлөгдөөгүй ажилд эрдэмтэн багш нарын хүч, нөөц зарцуулалтыг багасгах
- 2) Эм зүйч хөтөлбөрийг олон улсын магадлан шинжилгээнд оруулан төгсөгчидийн мэргэшлийн олон улсад хүлээгдэн зөвшөөрөгдөх баталгааг хангах

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем

1. АШУУИС-ийн “Эм зүйч” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлаж байгаа үзэл баримтлал нь:

Өвчтөн төвтэй Эмнэл зүйн эмзүйн тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэхэд сургалтыг бүхэлд нь чиглүүлэн зөвхөн эм хангамжийн мэргэжилтэн бэлтгэхээс татгалзсан

Сургалтын арга нь:

- Мэдлэгийг чадварт шилжүүлэн практикт хэрэглэх зарчим баримтлан Асуудалд, Чадамжид, Харилцаанд ба Даалгаварт суурилсан, Баг/бүлгээр ажиллах ба PPP чадвар эзэмшүүлэх аргаар сургалт явуулдаг
- Мэдээллэхээс шийдвэрлэх, Эмнэлзүйд ойртуулсан, Дидактикаас оюутан төвтэй, Хичээл хоорондын уялдааг сайжруулсан, Сурах арга барил эзэмшүүлэх, Багаар ажиллах чадвар эзэмшүүлэх заах арга зүйг гол болгосон

Үнэлгээний систем нь:

1. Багш, оюутны мэдлэгийн түвшинг үнэлэх, суралцах идэвхийг дэмжих, эрчимжүүлэх, өөрөө өөртөө дүгнэлт хий, төлөвлөх чадварыг нь багтаан үнэлэх явцын (форматив), төгсгөлийн (сумматив) үнэлгээний систем хэрэгжүүлж байна.
2. Явцын үнэлгээ нь оюутны сурах үйл ажиллагаанд туслах, дэмжих, урамшуулах зорилгоор сургалтын үйл ажиллагаанд нөлөөлдөг бол төгсгөлийн үнэлгээ нь сургалтын бүтэн мөчлөг явж дууссаны дараа оюутны мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлж үнэлгээний үнэн бодитой ба хүчин төгөлдөр байдлыг үнэлэх тогтолцоо ажээ.

2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал

- Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, эм зүйч мэргэжилтэний загвар зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан үзэл баримтлалыг мөрдлөгө болгон **Даяаршил, тасралтгүй төгөлдөршил, цахимжилтийн эринд дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн ажиллах,**

мэдлэг боловсролтой, урьдчилан сэргийлэлт оношлогоо, эмчилгээ, нөхөн сэргээхүйн өндөр технологийг эзэмшсэн, хүнлэг энэрэнгүй ёс суртахуунтай, ёс зүйтэй төлөвшсөн эмч, эмнэлэгийн мэргэжилтнийг бэлтгэн гаргахад хөтөлбөрийн үндсэн агуулгыг чиглүүлсэн

- Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн, эрдэм шинжилгээ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, ази номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг байхад оршино. гэсэн АШУҮИС-ийн эрхэм зорилготой уялдуулан **ЭЗС-ийн эрхэм зорилгыг Эмнэлзүйд суурилсан, сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажилыг олон улсын түвшинд хүргэх эмзүйн тусламж үйлчилгээг чанаржуулах хэмээн тодорхойлосон.**

- **АШУҮИС Мэргэжилтний цогц чадамж-ийн баримт бичгийг боловсруулсан ба тус сургуулийг эмзүйч мэргэжилээр төгсөгч нь: Тусламж үзүүлэгч, Харилцагч, Хамтрагч, Зохион байгуулагч, Эрүүл мэндийн зөвлөгч, Суралцагч, Мэргэжилтэн болсон** байна хэмээн хөтөлбөрийн хүрэх үр дүнг тогтоон ажиллаж байгаа нь чанарын ахиц гарган салбарын эрэлт хэрэгцээнд нийцсэн

3. Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

1. 2015 оны 1-р сарын 15-нд Эм зүйн мэргэжил эзэмшин төгсөгчийн цогц чадамжийн жагсаалт гаргах ажлын хэсэг байгуулж 1-р сарын 23 ний хурлаар төгсөн гарч буй эм зүйчийн үзүүлэх тусламж үйлчилгээ хийх үйлдэл, эзэмших цогц чадамж, цогц чадамж эзэмшихэд шаардагдах хичээл түүнчлэн эмзүйч мэргэжилтний эзэмших цогц чадамж-ийн бүтэц, хүрээ, нэгжийг урьдчилсан байдлаар тогтоон энэ хүрээнд Олон улсын эмзүйн холбоо(FIP. Global Competency Framework,2012) болон Канад улсад баримтлаж буй эмзүйчийн эзэмших цогц чадамж (National Association of Pharmacy Regulatory Authorities. Professional Competencies for Canadian Pharmacists at Entry to PrACTice), Ирландын мэс засалчдын эзэн хааны коллеж (RCSI)-ийн Эмзүйчийн үүрэг тэдгээрийн хоорондын харилцан холбоог харуулсан бүдүүвчид тулгуурлан АШУҮИС-ийн Эмзүйч мэргэжлээр төгсөгч нь харилцагч, хамтрагч, зохион байгуулагч, зөвлөгч, тасралтгүй суралцагч, мэргэжилтэн байж чадах эмзүйн тусламж үзүүлэгч байна хэмээн тодорхойлж 2-р сарын 2-ны хурлаар **Эм зүйн тусламж үзүүлэгчийн цогц чадамжийг бэлтгэх, үйлдвэрлэх, эмийн чанар, аюулгүй байдлыг хянах, эмзүйн албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, эмнэлзүйн эмзүйн тусламж үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх** гэсэн таван хүрээнд тодорхойлохоор тогтжээ

2. Дээд боловсролын тухай хуулийн 2-р бүлгийн 3.1-д заасан `Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан технологи хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ,үйлдвэрлэл, тусламж үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажилах судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар дадал эзэмшүүлэн. БСШУ-ны Сайдын 2002 оны 12-р сарын 31-ний өдрийн 390 тоот тушаал, 2006 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 481 тоот тушаал, Дээдэ Боловсролын тухай хууль 2-3.2.1.3.2.3 Сайдын 2006 оны 481 тушаал.

Дүгнэлт: Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой, төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Зөвлөмж: Сонгодог эм зүйч бэлдэж ирсэн туршлага, хүний нөөцийн боломжоо тооцон эмийн химич, эмийн технологч бэлдэх анги нээж эм зүйн салбарын хэрэгцээ захиалгаар мэргэжилтэн бэлдэх сургалт явуулах

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал

1. АШУУИС-д 1975-1990 онд мөрдсөн эм зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн харьцааг авч үзэхэд 1975 онд 43:11:46, 1978 онд 37:12:51, 1985 онд 47:28:25, 1987 онд 42:29:29, 1990 онд 21:34:45 харьцаатай байжээ.
2. 2005, 2008 оны эмзүйн сургуулийн сургалтын хөтөлбөрүүд нь шинэчлэгдэн багц цагийн хувьд нэмэгдэн ялангуяа 2008, 2010, 2015 оны хөтөлбөр нь эмнэлзүйд суурилсан шинэчлэгдсэн хөтөлбөр болсон.
3. Дээрх дараалалаар хичээл хоорондын харьцаа 30:40:30 басаныг **30:25:45** буюу багц цагаар авч үзвэл **49:40:75 нийт 173 кр.** Цаг болгож өөрчлөн Их сургуулийн эрдмийн зөвлөлийн 2015 оны 12-р сарын 01-ны тушаалаар батлагдан хэрэгжиж байна.
4. АШУУИС-ийн хэмжээнд **Анагаахын суурь хичээлийг** их сургуулийн 1 ба 2-р курст мэргэжил харгалзахгүйгээр нэгэн адил агуулгаар үзэж судлуулдаг болсон нь ялангуяа **Эмнэл зүйн эмзүйч** бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлж байгаа эдүгээ цагт нэн сайшаалтай бас оновчтой менежментийн хэрэгжүүлэлт болсныг зориуд цохон тэмдэглэж байна.

Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал

- Эмзүйн ангийн 3-р курсын оюутнууд эм зүйн мэргэжлийн суурь болох Ботаник, Эмийн ургамлын нөөц судлал гэх мэт хичээлүүдийг судлаж байна.
- Мэргэшүүлэх хичээлийг 3-5-р курстээ судлаж байгаа.
- Суралцах хугацаанд оюутан Эмийн хими, Эмийн үйлдвэр технологи, эмийн сангийн зэрэг нарийн мэргэжлийн хичээлийн үйлдвэрлэлийн дадалагыг хангалттай цагаар үр өгөөжтэй хийлгэж чимбай тайлан хамгаалуулж хэвшсэн.
- Суралцах хугацаанд гардан хийж сурах үйлдлийн жагсаалт тодорхой шалгаж үнэлэх тогтолцоотой байгаа нь мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх талаар сургалтыг үр өгөөжтэй болгосон.

Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

- Оюутан төвтэй, оролцоог дэмжсэн, чадамжид суурилсан, дадлагажуулах ба үлгэрлэх, судалгаанд суурилсан сургалтын менежмент, орчин, үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа.

- Сурах сургах үйл ажиллагааны өгөөжийг сайжруулахын тулд Ерөнхий ба мэргэжлийн суурьболон мэргэшүүлэх хичээлийн харьцаа 21:34:45 байсаныг 30:25:45 болгосон нь сургалтын процессыг Мэдээллэхээс шийдвэрлэх, Хангамжийн ажилтнаас эмнэлзүйд ойртуулсан, Дидактикаас оюутан төвтэй болгож улмаар Хичээл хоорондын уялдааг сайжруулан, Сурах арга барил болон Багаар ажиллах чадвар эзэмшүүлэх сурган сэтгэл зүйн аргад шилжих бодит боломжийг бүрдүүлсэн.

Дүгнэлт: Оюутан төвтэй сургалт явуулж тэдэнд төгссөний дараа биеэ даан сурах чадвар эзэмшүүлж байгаа бөгөөд зах зээлийн харилцааны нөхцөлд ажиллах чадвартай Эмнэл зүйн эмзүйч бэлдэж ТДС-ын хөтөлбөрөөр төгсөгчидийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлсэн байна.

Зөвлөмж: Төгсөгчдөд олгодог Эм зүйчийн дипломыг эмнэл зүйн эм зүйч гэсэн тодотголтой болговол эмнэлэгийн эмийн санд ажиллаж байгаа эмийн мэргэжилтэнд тохиромжтой байгааг анхаарч үзэх шаардлагатай.

1-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- **Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал**

АШУУИС-ийн Эм Зүйн сургуулийн хичээлийн байр нь 2014 онд ашиглалтад орсон, 8159 м² талбай бүхий 4 давхар хичээлийн байртай байна. 1 суралцагчид 3,2 м² талбай оногдож байгаа нь дээд боловсролын байгууллагад тавигдаж буй стандарт нийтлэг шаардлагын норм хэмжээг бүрэн хангаж байна.

Шинэ хичээлийн байртай болсноор сургалт, судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэл явуулах эрүүл аюулгүй тохилог, нөхцөлийг бүрдүүлж, багш, оюутнууд ажиллах, сурах боломжоор хангагджээ.

Сургуулийн барилга нь багш нарын 5 өрөө, анги танхим 16, лаборатори 5, эмийн сангийн өрөө 2, үйлдвэрийн өрөө 6, агуулах 2, туслах ажилчдын өрөө 2, оюутны кафе, фитнесийн өрөө, узелийн өрөө 4 нийт 42 өрөөтэй байна. Хичээлийн анги танхимаас гадна сургалт, үйлдвэрлэлийг хослуулан сургалт, үйлдвэрлэл, технологийн дадлага явуулах GMP хангасан эмийн үйлдвэрлэл, эмийн сан, лабораторийг шинээр тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хөндлөнгийн лабораторийн зөвшөөрөл аван ажиллаж байна.

Лекцийн танхимд орчин үеийн дэвшилтэт “Смарт индэр”-ээр тоноглон, сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Сургуулийн байр ашиглалтад орсноор багш, оюутнуудын баг хамт олноороо хичээлээ хийх, анги танхим хангалттай, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Оюутнууд хувийн шүүгээтэй болж, камер байршуулснаар хичээлийн ном, цүнх хувийн зүйлсээ хийж хадгалах, эд юмаа гээх, алдах, сургуулийн байранд хулгайн гаралт буурсан байна.

Шинжээчид анги танхим, лаборатори, эмийн үйлдвэр, эмийн сангийн үйл ажиллагаатай танилцаж, бие даалт хийж байгаа, хичээллэж байгаа оюутнуудтай уулзлаа.Тэд сургалт, судалгаа явуулах орчин, аюулгүй, тохилог байдалд сэтгэл хангалуун байлаа.

- Сургалт, судалгаа явуулах тоног төхөөрөмж, лаборатори тохижуулсан байдал

Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийг хослуулан сургалтын чанарыг сайжруулах зорилгоор эмийн үйлдвэр, эмийн сан, лабораторийг шинээр тохижуулж, ажиллуулах тусгай зөвшөөрлийг ЭМЯ, холбогдох байгууллагаас авч, үйл ажиллагаагаа явуулж байна.

Сургалтын танхимд сонсож, мэдсэнээ үйлдвэрлэл, лаборатори, эмийн санд дадлагажин, нүдээр үзэж, гараар барьж өөрсдөө хийх боломжоор бүрэн хангасан байна.

ЭЗС-ийн дэргэд эмийн ургамал судлалын лаборатори 2, эмийн ургамал судлалын лаборатори 2, эмийн технологийн лаборатори 2, микробиологийн лаборатори 2, Эмийн хими ба Эмийн чанарын хяналтын итгэмжлэгдсэн лаборатори 5 өрөөнд тус тус байрлаж, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Эдгээр лабораторийг 25 сая төгрөгийн лабораторийн зориулалтын ком тавилгаар тохижуулжээ. Мөн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.

Эмийн химийн лабораторид эмийн уусалт тодорхойлох аппарат, хийн хроматографи, компьютерт суурилсан спектрофотометр, вакуум ууршуулагч, вакуум фильтрийн аппарат, хэт ягаан туяаны анализатор, рефрактометр: Эмийн чанарын лабораторид орчин үеийн өндөр идэвхит шингэн хроматографи (52000\$ үнэ бүхий), спектрофотометр (5 сая₮), шахмал эмийн 4 үйлдэлт чанар шалгах машин (71 сая₮): Эмийн технологийн лабораторид нунтаг эм савлагч, хатуу эд нунтаглагч, жижиглэгч, холигч, үрлийн тогоо (30 сая₮) , ургамлын ханд, хандмалын хувийн жинг тодорхойлох пикнометр зэрэг, Эмнэл зүйн эм зүй, биофармацийн хичээлд хэрэглэгдэх TV, самбар, компьютер, уусалт тодорхойлох багаж, спектрофотометр зэрэг сургалт, судалгаанд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.

- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Хичээлийн шинэ байрны анги танхмыг тохижуулсан, цэвэрхэн, сургалтын LCD, проектор, Смарт дэлгэцтэй болгосноос гадна оюутнууд үнэ төлбөргүй интернэт ашиглах боломжтой болсон байна. Ингэснээр багш, оюутнууд тухайн хичээлийн талаар ямар ч шинэ мэдээллийг авах боломжтой болсон бөгөөд алсын зайн сургалтууд явуулж байна. Дотоод сүлжээ, мэдээллийн нэгдсэн санг ашиглах бололцоотой болсон бөгөөд 15 компьютер, проектор, дэлгэц, notebook бүхий сургалтын лабораторийг байгуулан, сургалтад ашиглаж байна. Номын сан, фитнес төв, ЭКО цогцолбор зэрэг оюутнуудын бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлж чадсан байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц бүлэгт SWOT шинжилгээ хийж, давуу, сул талаа тодорхойлж, өөрсдийн боломжоо тооцсон байгаа нь хөтөлбөрийн орчинг сайжруулахад үр дүнгээ өгсөн байна.

Зөвлөмж: Эм зүйн сургуулийн дэргэдэх Эм үйлдвэрлэлийн Судрын тун гарааны компанийг өргөтгөн хүчин чадал өндөр эмийн үйлдвэр болгон хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж ажиллах,

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- **Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж**

Эм зүйн салбар ухааны эм зүйн зохион байгуулалт, эмийн маркетинг, эмийн хими, эмийн технологи, уламжлалт анагаах ухаан, биофармаци зэрэг хичээлүүдээр үндэсний хэл дээр бичигдсэн сурах бичгүүдтэй (14), компьютерийн дотоод сүлжээ (сургалтын web, server, unimis) болон мэдээллийн нэгдсэн санг ашиглах боломжтой болсон байна. Хөтөлбөрийн хүрээнд Эм зүйн сургуулийн оюутнуудыг интернэт орчин, цахим сүлжээ ашиглах боломж нөхцөлөөр хангаж, хичээлд хэрэглэгддэг иж бүрэн тоногдсон компьютерийн танхимд бие даалт хийх, цахим мэдээлэл авах, цахим сурах бичиг, багшийн лекцийг судлах, сонсох бололцоог сайн бүрдүүлсэн байна.

Мэргэжлийн сурах бичгийн хангамж сайн, оюутнууд шаардлагатай үедээ өөрийн сургууль дээр байрлах номын сангаас номоо авах боломж бүрдсэн байна.

Эмийн талаар ажилладаг төрийн болон ТББ-тай хамтран ажиллаж, ЭЗС-ийн багш нар гишүүнээр оролцож, эм зүйн мэргэжлийн "Эм зүй" "Эмийн мэдээлэл", "Эм сэрэмж", "Эмийн увидас" сонин, сэтгүүлийг сургалтад ашиглаж байна. Багш нар Эмийн мэргэжлийн салбар зөвлөлд орж ажилладаг нь шинэ мэдээллийг шуурхай хүлээн авдаг давуу тал болдог байна. Эм шинжилгээний лаборатори нь улсын итгэмжилсэн лаборатори болсон байна. Судрын тун эмийн үйлдвэр, сорилын лабораториуд байгуулан ажилласан нь сургалт, судалгааны ажилд үр дүнгээ өгч байна..

- **Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ**

Эмийн мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн 24 нэр төрлийн гарын авлагыг сургалтад хэрэглэж байлаа. Хөтөлбөрийн агуулга, арга зүйд нийцсэн удирдамж, гарын авлага хичээл бүрт оюутнуудад хүрэлцээтэй байлаа. Эмийн ургамлын хичээл дээр хангалттай хатаамлууд байна. Эм зүйн чиглэлээр ордог бүх хичээл дээр хөтөлбөрийн агуулга, арга зүйд нийцсэн гарын авлага, удирдамж боловсруулан хэвлүүлж, оюутнууд хангалттай, хүрэлцээтэй ашиглаж байна.

Оюутны дадлага хийх түшиц байгууллагатай гэрээ хийж, ЭХНБ, эмийн үйлдвэрүүдтэй тохиролцсоны дагуу 4 эмнэлэг, 5 эмийн сан, 6 эмийн үйлдвэр, 4 ЭХНБ-д дадлага хийлгэдэг байна. Дадлага хийх удирдамжийн дагуу Эмийн ургамлын дадлагыг Горхит оюутны хээрийн дадлагын бааз дээрээ хийдэг байна.

Дадлага, гардан хичээлийн сургалтад ашиглагддаг эмийн дээж, индикатор бодис, урвалж бодис, органик уусгагч, эмийн ургамлын хатаамал, эмт бодис, түүхий эд, шил сав хангалттай байгаа нь оюутнуудын мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн дадлагын болон сургалтын чанарт сайн нөлөө үзүүлж байна. Энэ нь суралцагсдын сурлагын чанар жилээс жилд сайжирч байгаагаас харж болно.

Төгсөлтийн дараахи эм зүйч нарын сургалтын бааз болсон.

Зөвлөмж:

1. Эм зүйн сургуулийн сургалтад ашиглагддаг сурах бичгүүдийг цахим хэлбэрт бүрэн оруулах, зохиогчийн эрхийн асуудлыг шийдвэрлэх,
2. Судалгаа, шинжилгээнд шаардлагатай байдаг урвалж бодис, түүхий эдийн хангамжид шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг дараагийн 5 жилд нэмэгдүүлэх талаар анхаарах

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- **Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ**

2015 онд АУТ номын сан 848 м² талбайтай, хуучнаас 336 суудлаар нэмэгдүүлсэн байна. 130 хүний суудалтай уншлагын танхим, 6615 ном, сурах бичигтэйгээс 3219 нь мэргэжлийн сурах бичиг, оюутнууд хэрэглэдэг байна. 150'000 номтой, гэрээр 60'000 ном олгодог. Эдийн засгийн чиглэлийн 646 ном, гадаадын 259 сэтгүүл, hinary хандалтыг номын санд үнэ төлбөргүй ашигладаг.

Сүүлийн 5 жилд номын сан нийт 1,266,386 уншигчдад 259,669 ном олгож, үйлчилснээс 250'770 ном буцаан авч байршуулснаас гадна интернэт танхмаар нийт 198'556 уншигчдад үйлчилсэн байна. Номын санд ЭЗС-ийн **269** оюутан карт нээлгэж, номын сангийн үнэмлэх авсан байна. Гэрээр авч уншсан номыг ариутгалын боксоор оруулдаг нь эрүүл ахуйн шаардлагыг биелүүлдэг байна.. Ховор номыг файлаар хадгалдаг.

АШУҮИС нь шинэ төв номын сантай болсон нь оюутнууд эрүүл, тохилог бүхий л нөхцөл боломжоор бүрэн хангагдсан орчин нөхцөлтэй, сургалтад шаардлагатай ном сурах бичиг, гарын авлага, удирдамж, сэтгүүл хүрэлцээтэй, суралцагсдын сэтгэл ханамж өндөр байна.

Эрдэм шинжилгээний уншлагын танхимд мастер, докторын бүх диссартац эх сурвалжууд нээлттэй байна. Энд мастер лист үүсгэсэн, эм судлал, эм зүйн 84 магистрийн ажил, 28 докторын ажил хадгалагдаж, ашиглагдаж байна.

ЭЗС өөрийн хичээлийн байрандаа номын сан ажиллуулж, оюутнуудад шаардлагатай номоор үйлчилж байна. Мэргэжлийн сурах бичгийн хангамж сайн, оюутнууд шаардлагатай үедээ өөрийн сургууль дээр байрлах номын сангаас номоо авах боломж бүрдсэн байна. Энэ нь суралцагчдад ойр хөтөлбөрийн агуулга, арга зүйд нийцсэн үндсэн сурах бичгүүд хангалттай байгааг харуулж байна.

- **Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал**

2013 онд оюутнуудын дунд хийсэн судалгаагаар оюутны 67% цахим мэдээллийг ашигладаг, 65,8% компьютер, гар утсаараа интернэтэд холбогддог гэсэн дүгнэлтийг үндэслэн номын сангийн бүх нэгжүүдэд утасгүй интернэтийн төхөөрөмж суурилуулсан байна. АХБ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр WiFi орчин бүхий 30 ширхэг IPAD, 25 суурин компьютертэй цахим өрөөг оюутнууд ашиглаж байна. Аудио, видеогоор хичээл авч үзэх боломжтой болсон байна. Сүүлийн 3 жилд 226 цахим лекц бэлджээ. МАУ-ы цахим сэтгүүлийн санд АШУҮИС-иас эрхлэн гаргадаг 3 сэтгүүлийн 38 дугаарын 192 өгүүллийг цахимаар байршуулсан байна.

БСШУЯ-наас хэрэгжүүлж байгаа дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд “Ном сэлбэх, сэргээн засварлах” төсөл шалгарсан байна. АУТНС нь МУ-ын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үйлчилдэг улсын хэмжээний анагаах ухааны чиглэлийн төв номын сан болж, өргөжсөн байна.

- **Цахим орчны хүртээмж, хэрэглээ**

Монгол хэл дээрхи ховор сурах бичгийг скайнердэж, цахим хэлбэрт хөрвүүлэн ашиглаж байна. Гадаад ном худалдан авахдаа цахим хувилбарыг хамт авдаг байна. Цахим төвөөс боловсруулсан цахим лекцийг номын сангийн цахим танхимд байршуулсан байна. Шаардлагатай гадаад номыг цахимаар бүрдүүлснээр хэрэглэгч ашиглах боломжтой болсон. Цахим эх сурвалжийн хүртээмжийг нэмэгдүүлж, цахим лекц, цахим ном, сурах бичиг, эрдмийн бүтээлүүд он, оноороо хадгалагдаж, багш, оюутнууд төдийгүй эмч нарын хэрэгцээнд ашиглагдаж, улсын хэмжээнд эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлж байгаа нь тэдний сурч боловсрох нэг боломж юм.

- **Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал**

UniFasesистем нь веб орчинд ажилладаг. Unicode дэмждэг, цахим ном унших, онлайн захиалга хийх, Их сургуулийн удирдлагын системтэй холбогддог давуу талтай юм байна. UNIFACE системд орон нутгийн сургуулийн номын санг холбон оруулснаар оюутнууд цахимаар цахим ном, сурах бичиг, лекц ашиглах боломжтой болсон (Говь- Алтай, Дархан Уул, Дорноговь). Энэ системд номын санд байгаа сурах бичгүүдийг агуулгаар нь холбогдох хичээлүүдтэй холбож өгснөөр оюутан тухайн хичээлтэй холбоотой ямар сурах бичиг байгааг мэддэг юм байна. Энэ нь орон нутгийн суралцагч оюутнууд мэдээллээс хоцрохгүй байх боломжоор нь хангасан. Онлайн мэдээллийн сангийн хандалтын тоо дунджаар 30-40%-иар өссөн байна.

HINARI хандалтыг 2005- 2014 онд үнэ төлбөргүйгээр, 2014 оноос бага зэргийн төлбөртэй ашиглаж байна. Багш, оюутнуудыг хайлтын системийн ашиглалтын талаархи сургалтад хамруулснаар Scholar, Google ийн ашиглалт 89,5%, HINARI хандалтын ашиглалт 97,4%-иар өссөн байна.

БСШУЯ-ны төслөөр Springer, EnscoHost мэдээллийн сангуудыг 1 жилийн хугацаагаар ашиглаж байна.

Зөвлөмж:

- Онлайн мэдээллийн санд хандагсдын тоо эрс нэмэгдэж байгаа тул сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтыг өргөжүүлэх,
- “Ном сэлбэх, сэргээн засварлах” төслийг амжилттай хэрэгжүүлэх,

2-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Шинжээчийн дүгнэлт: Бүрэн хангасан

3.1.1. Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал

А. Энэхүү төлөвлөгөөг боловсруулах үйл явц 2 жил үргэлжлэх хугацаанд оюутны төлөөлөлтэй 3 удаа ярилцлага зохион байгуулсан ба 2016 оны 3-р сард Эм зүйн сургуулийн бүх оюутан оролцсон хурал хийж төслөө танилцуулан санал авч гарсан саналыг ач холбогдолоор нь бүлэглэн холбогдох тэнхимийн хуралд хэлэлцүүлэх ажил зохион байгуулжээ.

В. Мөн төгсөгчид, Ажил олгогчдын саналыг авах зорилгоор Эм холбоотой хамтран 1 удаа Онлаинаар, 1 удаа цаасаар асуумж тараан судалгаа хийсний дараа төлөөлөлтэй уулзалт 1 удаа зохион байгуулж гарсан саналыг тусган **+3 хөтөлбөр боловсруулан** шинэ хөтөлбөрөөр суралцан төгсөгчидийн мэргэшлийн онцлогийг талбарлан таниулах ажил зохион байгуулсан байна.

С. ЭЗБАС-ийн тэнхэмийн эрхлэгчдийн хурал 14 хоногт 1 удаа жилд 18-19 удаа, тэнхэмийн хурал 14 хоногт 1 удаа жилд 2 удаа биш оюутнуудтай уулзалт хийж

Д. АШУУИС-ийн хэмжээнд **Цахим удирдлагын UNIMIS- 5** програм нэвтрүүлсэн бөгөөд захиралаас багш хийгээд оюутан, захиргаанаас тэнхим хийгээд нэгж хүртэл бүхийл үйл ажиллагааг цахим системд оруулж **Сургалтын бодлого-зохицуулалтын алба** (дарга Оюунгоо) нь шуурхай бөгөөд үр дүнтэй нэгж, нийт хамт олондоо хүрсэн удирдлага мэдлээлэлийн тогтолцоог бүрдүүлж чадсан байна гэж үнэлгээний баг үзсэнийг тэмдэглэж байна.

3.1.2. Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал

Орчин үеийн техник технологийн бүхий эрдэм шинжилгээ, судлагааны төв, лабораториудыг олон улсын түвшинд хөгжүүлэх, үндэсний брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн салбарын хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах сургалтыг олон улсын түвшинд хүргэх, Их сургуулийн эмнэлэг байгуулж эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гэх мэт зорилтуудыг тавьсан.

3.1.3. Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт

А. АШУУИС-ийн дүрэм, БШУСЯ-ны баталсан журмын дагуу сургалтын төлөвлөгөө боловсруулах батлах өөрчлөх үйл ажиллагааг зохион байгуулдаг.

В. Эм зүйн сургууль түүхэн хөгжилийнхөө хугацаанд Сургалтын төлөвлөгөөгөө 9 удаа өөрчилсөн.

С. 2015 онд одоогийн мөрдөж байгаа Сургалтын төлөвлөгөөг Эм зүй-Биоанагаахын сургуулийн эрдэмтэдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн улмаар АШУҮИС-ийн Эрдмийн их зөвлөлийн хурлын 15/11-тоот тогтоолоор баталгаажуулан мөрдөж байна.

3.1.4. Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм

“АШУҮИС нь хөгжийн бодлогыг 2015-2024 оноор тодорхойлохдоо Ази номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 сургуулийн нэг болно” хэмээн тодорхойлсон. Энэхүү бодлогын хүрээнд: **Сургалтын их сургуулиас судалгааны их сургууль болох** зорилготой ажиллаж байгаа юм байна.

3.1.5. Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.

А. ЭЗБАС-ийн багш оюутны нээлттэй өдөрлөг нь багш оюутнуудыг хооронд нь холбох найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх зорилготой мөн тус сургуулийн оюутнуудын өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг сургуулийн удирдлага, эрдэмтэн багш нартайгаа хуваалцах, зохицуулах арга замыг хамтран хэлэлцдэг.

В. ЭЗБАСОН-ийн тэргүүнээр тус сургуулийн 5р дамжааны оюутан Б.Солонго сонгогдон ажиллаж байна. Эмзүйн ангийн оюутнууд сургалттай холбоотой саналаа өөрийн биеэр болон ЭЗБАСОН-ээр дамжуулан СБЗГ-ийн төгсөлтийн өмнөх сургалтын алба болон холбогдох тэнхимд өгдөг ба хичээл дууссан тухай бүр багш нар заасан, хичээлийн холбогдолтой санал асуулгыг аван үйл ажиллагаандаа тусгаж ажилладаг.

а. Сургуулиас санал болгосон хичээлээс сонгон судлах, хувийн төлөвлөгөө гаргах зөвлөгөө чиглэл авах, суралцах хугацаа, хэлбэрийн талаар санал тавьж шийдвэрлүүлэх:

б. Сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шаардлага тавих:

с. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхэд өөрөө болон төлөөлөн оролцох эрхтэй байна хэмээн тодорхойлсон байдаг.

д. Мөн оюутны ар гэрээс санал гомдол гарвал тавьж буй асуудлын хүрэнээс шалтгаалан тэнхэм, салбар, бүрэлдхүүн сургууль, холбогдох албадууд, захиргааны зөвлөлийн хэмжээнд хэлэлцэн зохих шийдвэр гаргадаг ба буцаан мэдээллэх үүргийг салбар нэгж хүлээдэг.

С. Эм зүйч мэргэжилийн хөдөлмөрийн зах зээлийн судлагаа явуулах: Ажил олгогч байгууллагуудын тухайлбал эм хангамжийн байгууллагуудын удирдлагуудыг жил бүрийн 4,5 сард хүлээн авч уулзалт хийх

Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судлагааг 2 жил тутам хийж ажил олгогч байгууллагуудын тухайлбал эм хангамжийн байгууллагуудын удирдлагуудыг сүүлийн 3 жил 4,5-р сард хүлээн авч уулзалт хийдэг ажлыг хэвшүүлсэн байна. Эм хангамжийн байгууллагын мэргэжлийн ажилтнуудын ажлын байр нь улсын стандарт(Эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага MNS 5524:2014 эм эмнэлэгийн хэрэгсэлийн хадгалалт түгээлтэд тавигдах ерөнхий шаардлага 6439:2014, эмийн сангийн стандарт MNS

5260:2015) -ын дагуу тодорхойлогддог. 2014 онд хийсэн судалгаагаар тус онд төгссөн нийт 68 төгсөгчидийг судлагаанд хамруулсан. Судлагаанд хамрагсагдын 5/7%/ нь эрэгтэй, 63/93%/ эмэгтэй, 31/46%/ нь 2013 оны төгсөгчид 39/54%/ нь 2014 оны төгсөгчид байжээ. Судалгаанаас үзэхэд судалгаанд оролцогчдын 39% эмийн санд, 20% эм ханган нийлүүлэх байгууллагад, 20% эмнэлэгт, 9% эмийн үйлдвэрт 5% төрийн албанд 2% эм шинжилгээний лаборторт бусад 5% нь төлөөлөгчийн газарт эм зүйч, жирэмсний амралттай байна гэж тус тус хариулжээ.

Эм зүйн тэнхэм нэртэйгээр 1961 онд байгуулагдаснаас хойш эм зүйч мэргэжлээр нийт 43 удаагийн төгсөлт хийж 1221 мэргэжилтэн төгсгөсөн байна.

АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн сургалтын чанар мэргэжилтний чадавхи практик шаардлага, салбарын хэрэгцээнд нийцэмж сайн байдаг нь олон жилийн туршилтаар нотлогдсон учир төгсөгчдөд ажлын байр олох үзүүлэлт өндөр, төдийгүй тэдний ажиллаж сурч байгаа түвшинг авч үзэх боломж харагдна тухайлбал 2011-2015 онд төгссөн нийт 245 төгсөгчдөөс: их дээд сургуульд багшилж байгаа **5**, төрийн байгуулгад мэргэжлээрээ ажиллаж байгаа **24**, үргэлжлүүлэн суралцаж байгаа давхардсан тоогоор **32**, гадаад суралцаж байгаа **16**, хувийн хэвшлийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж **145**, АШУҮИС-ийн магистрантурт **8**, Эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж буй **6**, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын байгууллагад ажиллаж буй **4**

3.1.6. Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

1. Эм зүйн сургууль одоо 24 багштай дундаж нас 39,4 бөгөөд 50-иас дээш настай 3, 35-49 насны 13, 34 хүртлэх насны 8, гадаадын иргэн 3 тус тус ажиллаж байна. Ирээдүйд багшлах хүний нөөцөд зарим төгсөгч, одоо суралцаж буй ахлах ангийн оюутаны бүртгэл судалгаа гаргасан.

2. Эрдэм шинжилгээ хөгжүүлэх хүрээнд:

а. Эмзүйн сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний ажлын чанар үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт нь нийтлүүлсэн ЭШ бүтээлээр цуглуулсан IF оноо 0,9-8,9

б. Цаашид хийх эрдэм шинжилгээний ажлын хүрээнд 1багшид ноогдох эрдэм шинжилгээний бүтээлийн тоог нэмэгдүүлэх, Хэдийгээр итгэмжлэгдсэн лаборатортой болсон ч Лабораторын тоног төхөөрөмжийг ОУ-н түвшинд хүргэх, эхлэл байна.

в. Их сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээний өгүүлэлд тооцох урамшуулалын гаргаж 1-5 сая төгрөгийн урамшуулал олгодог журам бодитой хэрэгжиж байгаа.

с. Магистр, Докторантурт элсүүлэх амжилттай сургах, судлуулах, хамгаалуулах үйлсийг дэмжих зорилгоор 100000-200000 төгрөгийн урамшуулал өгөх эсвэл магистрын ажлын удирдагч, зөвлөхөд 4,5 ба 1,5 кредит, доторын ажлын удирдагч зөвлөхөд 9 ба 3 кредит цагийн гүйцэтгэл тооцох, түүнчлэн үндсэн багш доторантаар элсэн суралцвал сургалтын төлбөрийг 30 хувиар бууруулах зэрэг журам хэрэгжиж байгаа юм байна.

1. 2015-2016 онд магистрантурын сургалтанд 7 суралцагч шинээр элсэн орсон байна. 2011-2012 оны хичээлийн жилд 4, 2012-2013онд 8, 2013-2014 онд 8, 2014-2015 онд 1, 2015-2016 онд 9 эм зүйч магистрантурын сургалтын хөтөлбөрөөр тус тус суралцаж төгссөн байна. Эм зүйн сургуулийн магистрантурт шинээр элсэн орж байгаа суралцагчдын дунджаар 88,5% нь төгссөн.

2. Докторантурт элссэн суралцагчдын тоог авч үзвэл 2011-2012 оны хичээлийн жилд **5**, 2012-2013 онд **2** , 2013-2014 онд **6**, 2014-2015 онд **3**, 2015-2016 онд **2** суралцагч шинээр элсэн орсон байна. Үүнээс 2011-2012 онд төгссөн **1**, 2013-2014 онд төгссөн **0**, 2013-2014 онд **1**, 2014-2015 онд **4**, 2015-2016 онд **1** эм зүйч тус тус докторантурын сургалтын хөтөлбөрийг дүүргэж эрдмийн зэргээ амжилттай хамгаалсан байна. Эм зүйн чиглэлээр шинээр докторантурт элсэн орж байгаа суралцагчдын дунджаар 44,0% нь төгссөн.

3. Багш нарын ажлын үнэлэмжийг Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Их сургуулийн Хөдөлмөрийн дотоод дүрэм, ажлын байрны тодорхойлолт зэрэг үр дүнд суурилсан хэмжүүрийн тогтолцоонд оруулсан байна. Өөрөөр хэлбэл багш ажиллагсадын ажлыг үнэлэхдээ ажлын цаг ашиглалт, давхар ба нэмэлт болон сургуулиас гадуур эрхлэн гүйцэтгэсэн ажил, хариуцах анги танхим, эд хөрөнгө, хүлээх хариуцлагаба ёс зүйн хэм хэмжээ зэргийг тусган багшийн зэрэглэл харгалзахгүйгээр 1600 онооны системтэй 440-560 цагийн хичээл заахаар тогтоосон юм байна.

4. “АШУҮИС-ийн багш нь Ази номхон далайн баруун эргийн бүсийн шилдэг их сургуулийн багш болон хөгжиж, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэх их үйлсэд сургалт, эрдэм шинжилгээний олон улсын хэмжээний манлайлагч байна” гэж багшлах хүний нөөцийн алсын харааг тодорхойлон багшийн хөгжилийн удирдлага менежментийг их сургуулийн Сургалтын бодлого зохицуулалтын албатай хамтран бүртгэлжүүлэх, хэрэгжүүлэх үйлсийг зохион байгуулж байгаа юм байна.

5. АШУҮИС-ийн хэмжээнд Анагаах ухааны боловсрол судлалыг судалгааны нэгэн чухал топик болгон хөгжүүлж байгаагийн дотор **Эм зүйн сурган судлалын** чиглэлийг бас анхааран хөгжүүлэх эхлэл тавигдсан.

6. Анагаах ухааны боловсрол судлалын хүрээнд PBL, Судалгааны арга зүй, Үнэлгээний хөгжил, Сургалтын мэдээлэл технологи, сурган заах арга зүй зэрэг чиглэлээр өргөн цар хүрээтэй бөгөөд өгөөжтэй ажил зохион байгуулж байгаа

Дүгнэлт: Эм зүйч хөтөлбөр нь удирдлага зохион байгуулалтын хувьд суралцагчидад үзүүлэх сургалтын чанарыг эрс сайжруулах, нийгмийн хариуцлагыг улам бүр дээшлүүлэх, сонирхогч талуудын санал хүсэлтийг идэвхтэй судлах сургалтын агуулгад тусгах тасралтгүй үйл явц болсон байна.

Зөвлөмж: Хөтөлбөрийн удирдлага менежментийн хүрсэн түвшинг тогтвортой хадгалан улам хөгжүүлэх

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Шинжээчийн дүгнэлт: Бүрэн хангасан

3.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- АШУҮИС-ийн хэмжээнд Хөтөлбөрийн маркетингийн үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар тусгайлсан төлөвлөгөө гарган удирдлага менежментээр ханган, хөрөнгө санхүүгийн механизмыг бүхэлд нь шийдвэрлэж байгааг Үнэлгээний баг газар дээр нь үзэж танилцасныг тэмдэглээд Эм зүйн сургуулийн хүрээнд жил бүрийн 3-4 сард эм хангамжийн байгууллагуудын удирдлагыг хүлээн авч уулзалт хийдэг болсон ба 2014 оноос Төгсөгчидийн ажил эзэмшилтийн түвшин тогтоох зорилгоор тандан судалгаа хийж үр дүнд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн 10-12-р анги төгсөгчидөд чиглүүлсэн сурталчилгааны олон хэлбэрийн ажил зохион байгуулдаг болжээ.

3.2.2. Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

1. Анагаахын сургалтын чанарын баталгааны үр дүн /КРШ/-гийн үзүүлэлт гарган хөтөлбөр шинэчлэх (9 удаа)ажлыг зохион байгуулж байна.

2. Элсэгчидийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Хөтөлбөрийг нийтэд бүх хэлбэрээр мэдээлэх, хөтөлбөрийн сан бүрдүүлэх, уулзалт ярилцлага зохион байгуулах, сургуулийнхаа дэргэд гарааны компани байгуулах, сургалтын орчинг сайжруулах, шинэ бренд эм гаргах, багш судлаачдынхаа эрдэм шинжилгээний бүтээлийг эргэлтэнд оруулах, мэдээлэлийн тархалтын үнэлгээ гаргах зэрэг олон хэлбэрийн ажил зохион байгуулж байгаа юм байна.

3. Элсэгчидийн тоо эрс өсөн 2011 онтой харьцуулвал тус салбарт 4,2 дахин өссөн байна.

Дүгнэлт: Хөтөлбөрийн зах зээлийн тандалт маркетингийн идэвхжүүлэлтийг амжилттай хийж байгаагийн үрээр Эмийн мэргэжлийн чиглэлээр сургалт явуулдаг сургуулиудаас хамгийн олон элсэгчтэй, нэр хүндтэй сургууль болж чадсан.

Эм зүйн сургууль нь сургуулийнхаа үйл ажиллагааг монголын эм зүйн салбарын нэр хүнд гэж үздэг бөгөөд энэ нь тус хөтөлбөрийн маркетингийн давуу чанар гэж үнэлэж болхоор байна.

Зөвлөмж: Монголын боловсролын салбарын эм зүйн сургалтын дэг, мэргэжилтний загвар бодлогыг авч явах тэргүүлэх байгуулгын үүргээ ухамсарлаж өргөн цар хүрээтэй ажиллах

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

3.3.1 Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа

2011-2015 онд төгсөгчидөөр жишиж үзвэл: Их дээд сургуульд багшилаж буй – 5, Эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж буй 6 Төрийн байгуулгад мэргэжлээрээ ажиллаж байгаа 24, Хувийн хэвшлийн байгууллагад мэргэжлээрээ 145, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын байгууллагад ажиллаж буй 4.

3.3.2 Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ

- Эрдмийн зэргийн сургалтанд суралцагсадын судалгааг авч үзвэл сүүлийн 5 жилд тус эм зүйн сургуулийг 345 хүн төгссөнөөс 2012 онд 4 (5,5%), 2013 онд 8(10,2%), 2014 онд 8(14,8%), 2015 онд 1(1,6%), 2016 онд 9(11,6%) магистрантурт, 2012 онд 5(6,75%), 2013 онд 2 (2,56%), 2014 онд 6(11,11%), 2015 онд 3(4,83%), 2016 онд 2(2,59%) тустус доторантурт элсэн суралцаж байгаа юм байна.

- Магистрантурт суралцагсадын судалгааг авч үзвэл сүүлийн 5 жилд тус сургуулийн магистрантур, докторантурт элсэн суралцагчидын 8,3 – 100 хувь амжилттай хамгаалжээ.

3.3.3. Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдалт

1. Төгсөлтийн дараах сургалтын үндсэн 4 хэлбэрийг хэрэгжүүлж байна. Үүнд: Урт богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, Мэргэжил олгох 6 сарын сургалт, Магистрантурын 2 жилийн сургалт, Докторантурын 3 жилийн сургалт
2. Богино хугацааны сургалтад сүүлийн 6 жилд 4357 мэргэжилтэн хамрагдсан байна.
3. Сарын сургалтанд хамрагдагсадын тоо 1,6 дахин өссөн

3.3.4. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

1. АШУҮИС-ийн дэргэд 2015 онд БСШУ-ны сайдын А/134 тоот тушаалаар Төгсөгчидийн холбоо байгуулагдсан ба гол үйл ажиллагаа нь:
Алтан гануур төгсөгчидийн 10 жил тутмын чуулга уулзалт, 21 аймагт салбар зөвлөлтэй, 5 жил тутамд орон нутагт очиж зохион байгуулдаг багц цагийн Багш шавийн уулзалт сургалт
2. Эм зүйн залуу мэргэжилтний клубын хийдэг сургалтын үндсэн чиглэл нь:
Нээлттэй засаглал, Нэг санаа нэгдмэл зорилго, Хариуцлагатай байдал

3. Салбарын чадавхи сайжруулах зорилгоор Фарма –Мондиал байгуулгатай хамтран дараах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан Үүнд:

ISO 9001-2015 сургалт, Эмийн мэргэжилтний ёс зүй сургалт, Клиник эмзүйн сургалт, Эмийн үйлдвэрийн чанарын баталгаажилт, Эм зүйн мэргэжилтний андгай өргөх ёслол, Олон улсын эм зүйчидийн өдөрлөг

Дүгнэлт: АШУҮИС-ийн Эм зүйн сургууль Эм зүйч хөтөлбөрийг урьд урьдынхаас илүү үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төгсөгчидийн төгсөлтийн дараах байдал тухайлбал ажил эрхлэлт, карьерын өсөлт, сургалтанд хамрагдалт зэргийг анхааран Төгсөгчидийн холбоог дэмжин байгуулж түүгээр дамжуулан өгөөжтэй олон талт ажил хийж эхэлсэн байна.

Зөвлөмж: Магистрантур, Докторантурын элсэлтийн хүрээг өргөтгөх бодлого баримтлах

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

3.4.1. Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт

1. Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр 2011 оноос хойших хугацаанд шинээр байгуулсан гэрээ 18, Хамтын ажиллагаатай их дээд сургууль байгуулага 21 байна.

2. Токушима – Монгол орны угсаатны эмийн ургамлын судалгаа 2010-2016, БНХАУ-ын ӨМҮИС – Уламжлалт эмийн үйлдвэр байгуулах 2016, Айрагнаас эмийн бэлдмэл гарагн авах 2015-2016, ӨМОУЭХ- Монгол орны эмийн ургамлын хэрэглээ 2016-2017, Азын хөгжилийн банк Аймаг орон нутаг дахь хуурамич, бүртгэлгүй эмийн судалгаа 2012-2013, Улсын нийслэл дэх хуурамч, стандартын бус, бүртгэлгүй эмийн судалгаа – 20123-2013, ДЭМБ- Эмийн сайн засаглал 2013, Эмийн аюулгүй байдалын дэглэм сайжруулах 2012-2016, ИҮНСөи их сургууль – Ховор эмийн ургамлын эдийн өсгөвөр 2011-2012, АХБ- Эмийн аюулгүй байдалын дэглэм сайжруулах 2011-2012 зэрэг гадаад улс ба Олон улсын байгуулгатай хамтарсан төсөл хэрэгжүүлсэн байна.

3.4.2. Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо

1. Гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан багш - 2, Гадаадад сургалтанд хамрагдаж байгаа багш - 15

2. Гадаадад их дээд сургуульд зочилсон оюутан -30, Гадаадаас зочилж ирсэн оюутан -31, Одоо суралцаж байгаа гадаад оюутан -1

3. Гадаадын шагнал, тэтгэлэг авсан оюутан - 2

4. Оюутан солилцооны гэрээтэй их дээд сургууль - 3

3.4.3. Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

1. Зохион байгуулсан олон улсын хурал - 1

2. Олон улсын эрдэмшинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл – 59

3. Гадаад сэтгүүлд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл -25

Дүгнэлт: Эм зүйч хөтөлбөрийн хөгжилийг хангахын тулд гадаадын их дээд сургууль олон улсын 44 байгуулгатай хамтран ажиллаж төсөл хөтөлбөр хэрэгжүүлж багш, оюутан солилцож, Олон улсын хамтын ажиллагааны үр нөлөөг сайжруулах талаар санаачлагатай үр бүтээлтэй ажиллаж байна.

Зөвлөмж: Сургуулийн дэргэдэх эмийн үйлдвэрлэлийн салбарын гадаад хөрөнгө оруулалт, хамтын үр өгөөжтэй ажиллагааг хөгжүүлэх

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

3.5.1.Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн

Эх орны төрийн ба хувийн хэвшлийн, төрийн бус 100 гаруй байгуулгатай 2011-2016 онд

1. Сургалтын чиглэлээр – Үйлдвэрлэлийн дадлага хийх,
2. Эрдэм шинжилгээний чиглэлээр – 15 төсөлт эрдэм шинжилгээний ажил хийсэн
3. Мэргэжлийн чиглэлээр – Яам, мэргэжлийн холбоодын 30 шахам үйл ажиллагаанд багш нар томилолт тушаалаар оролцон салбарын хэмжээний бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад оролцсон

3.5.2.Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт

1. 2011-2016 онд хэрэгжсэн төслүүдийн үр дүнгээр эмзүйн салбарын багш судлаачид нийт 349 бүтээл гадаад, дотоодод нийтлүүлсэн. Үүнд:Нэг сэдэвт бүтээл,ном тохимол 35, Эрдэм шинжилгээний өгүүлэл 207 (гадаад,29 дотоодод 178), Эрдэм шинжилгээний илтгэл 85(гадаадад 32, дотоодод 53), Батлагдсан стандарт технологийн заавар 22, Патент ашигтай загвар 8

2. Хэрэгжиж буй төсөлт ажилуудыг санхүүжилтын байдлаар авч үзвэл:

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2, Эрүүл мэндийн яамнаас 1, БСШУСЯ-1, БСШУСЯ, Азийн хөгжлийн банк 3, АШУҮИС, ШУТДС- ын санхүүжилтын төсөл 3, ШУТС 3, НҮБ-ын хүн амын сан 1

3.5.3. Хамтын ажиллагааны арга, туршлага

-Ажлын хэсэг байгуулан ажиллах

-Хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх (эмийн марктенгийн судалгааны эмийн чанарын хяналтын шинэ эм бүтээх, эмийн фармакопейн өгүүлэл хамтарч боловсруулах гэх мэт)

-Хамтарсан судалгаа хийх

-Эм зүйн чиглэлээр хамтарсан олон улсын болон улсын чанартай эрдэм шинжилгээ практикийн хурал зохион байгуулах

-Танхимын болон ажлын байран дахь сургалт зохион байгуулах

-Эмэн эмчилгээнд үнэлгээ хийх

-Эмчилгээний удирдамж боловсруулах

-Өдөрлөг зохион байгуулах гэх мэт ажилуудыг хийж байна.

3.5.4. Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Дүгнэлт: Дотоодын мэргэжлийн байгууллагуудад мэргэжлийн тусламж үзүүлэх, тэдний үйл ажиллагааг дэмжих, хамтран улсын хэмжээний хурал, сургалт, семинар зохион байгуулах, өөрийн оюутны үйлдвэрлэлийн дадлага хийлгэх зэрэг хамтын ажиллагааг үр дүнтэй явуулж байна.

Зөвлөмж: Сургалтын агуулгадаа нийцсэн “Эмэнд суурилсан эмнэлзүйн удирдамж” боловсруулж сургалт, эмнэл зүйн практикт нэвтрүүлэх

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

3.6.1. Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил

1. АШУУИС-ийн хэмжээнд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол улсын хуулийн дагуу төвлөрүүлэн захирч, зарцуулах журмаар үйл ажиллагаа явагдаж байгаа нь Монгол улсын санхүүгийн талаар баримтлаж байгаа хууль эрхийн орчинд нийцнэ.
2. АШУУИС-ийн хэмжээнд мөрдөгдөж байгаа Хөгжилийн бодлогын баримт бичигт төсөв санхүүгийн эх үүсвэрийг олон талтай болгох, биеэ даасан байдлыг сайжруулах талаар заалт оруулсан байдаг хэдийч дээр тэмдэглэсэнчлэн төсөв захиран зарцуулагч цор ганц байх тухай хууль эрх зүйн баримт бичигт өөрчлөлт орох хүртэл хэрэгжих хараахан боломжгүй юм.
3. Хэдийгээр хууль эрх зүйн орчин ийм байгаа чгэсэн санхүүгийн эрх чөлөөний боломж олгох хүрээнд АШУУИС-ийн захиргаа бүрэлдэхүүний ба харьяа сургуулийн жилийн төсвийг нэгжээс авч, аль болох нэгж байгууллагын саналыг үндэслэн төсөв зохиох санхүүжилт, хуваарилалтыг хийх талаар багагүй санаачлага гарган ажилласан байна.

3.6.2. Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

Нэг оюутанд ногдох зардал жилээс жилд өсч байгаа юм байгааг дараах хүснэгтээс харж болно.

№	Хичээлийн жилд	Бүтэц	Төлөвлөгдсөн Төсөл	Оюутны тоо	Нэг оюутанд ноогдох дүн
1	2011он	ЭЗС	138583	285	486,26
2	2012он	ЭЗС	217969,7	306	712,32
3	2013он	ЭЗС	358503,6	344	1042,16
4	2014он	ЭЗБАС	1,841,604,50	1307	1409,03
5	2015он	ЭЗБАС	2,908,252,50	2003	1451,95

3.6.3. Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв

1. 2015 оны байдлаар Эм зүйн сургуулийн төсөвийн зардалын бүтэцийг авч үзвэл цалин хөлс 68,5, сургалтын зориулалттай бусад зардал 19 хичээл практик, ном хэвлэлийн зардал 13 хувийг тус тус эзлэж байна.
2. Хөтөлбөрийн бус үйл ажиллагаанд хөрөнгө үргүй зарцуулагдсан тухай санхүүгийн ба баримт бичгийн хяналт, аудитын шалгалтаар ямар нэг зөрчил илрээгүй байна.

3.6.4. Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт

1. Сүүлийн 3 жилийнхээр Эм зүйн сургууль төсөв бүрдүүлхэд өөрийн хувь нэмэр санаачилгаа хандуулсны үрээр 31 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

2. Их сургуулийн захиргаа өөрийн сургуулийн үйл ажиллагаа, хандив, тусламжаас олсон орлогод хатуу хязгаарлалт тавьдаггүй учир урсгал мөнгөний хэрэгцээнд зарцуулсан байна. Зарцуулалтын тайлан мэдээ, баримтын бүрдэлдийг их сургуулийн санхүүгийн алба зохих хэмжээнд хяналт тавьдаг нь харагдаж байна.

3.6.5. Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

1. Дараах эх үүсвэрээс бүрддэг юм байна. Үүнд: Хичээл нөхөлтийн төлбөр, Өвөл, зуны дахин сургалтын төлбөр, Дахин нөхөн шалгалтын төлбөр

2. Их сургуулийн захиралын А/102 тоот тушаалын дагуу эдгээрээс орсон орлогын 50 хувийг сургуулийн төсвийн гаднах орлогод тооцон үлдсэн 30 хувийг багш ажиллагсадын ажлын хөлсөнд, 20хувийг багш, оюутныг хөгжүүлэхэд зарцуулдаг юм байна.

Дүгнэлт: Эм зүйч хөтөлбөрийн санхүүжилтийг бүрдүүлэх, төсөв хувиарлах, зарцуулах үйл ажиллагаа Монгол улсын санхүү бүртгэлийн хуулийн нөхцөлд зөрчилгүй явагдаж байна. Төсөв бүрдүүлэхэд сургуульхамт олон боломжийн хэмжээнд ажиллаж үйл ажиллагааны ба хандив тусламжийн замаар бага ч гэсэн нэмэр хандив олж байна.

Зөвлөмж: Эм зүйн сургуулийн дэргэдэх эмийн үйлдвэрийг өргөтгөн байр, тоног төхөөрөмжөөр ханган Эм үйлдвэрлэлийг эрчимжүүлвэл төсөвт жинтэй хувь нэмэр орох боломж байгааг анхаарах хэрэгтэй

3-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- **Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал**

БСШУСЯ-наас баталсан оюутан элсүүлэх журмын дагуу элсэлтийн үйл ажиллагааг явуулдаг. АШУҮИС нь бакалаврын ангид элсүүлэх оюутны тоог гаргаж, сонгон шалгаруулах, элсүүлэх ажлыг сургуулийн оюутан элсүүлэх журмаар зохицуулдаг байна. Захирлын тушаалаар элсэлтийн комисс томилж, энэ комисс элсэлтийн үеийн үйл ажиллагааг зохицуулдаг ба АШУҮИС-д оюутан элсүүлэхэд БСШУЯ-ны сайдын 2013 оны А/79 тушаалаар батлагдсан Оюутан элсүүлэх журам, 2015-2016 оны хичээлийн жилд АШУҮИС-ийн захирлын тушаалаар батлагдсан журмыг мөрдөж байна.

- **Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа**

Элсэхийг хүсэгчид ЭШ-ын хичээл тус бүрд 400-аас дээш оноотой, голч дүн 3-аас дээш. ЭЗС-д 2011- 2014 онд 305 оюутан элсэн суралцсан. Элсэлтийн дундаж оноо 631,6 байна.

АШУҮИС-д 2011-2015 онд элсэн суралцсан элсэгчдийн тооноос харахад ЭЗС-д 2011 онд элссэн нийт оюутны 6,87%, 2012 онд 8,27%, 2013 онд 5,79%, 2014 онд 9,9% элсэн оржээ. Энэ үзүүлэлтээс элссэн оюутны тоо өссөн байна. Эм зүйн бакалаврын хөтөлбөрөөр 2011 онд 63, 2012 онд 81, 2013 онд 59, 2014 онд 102 оюутан элсэн орсон байна. 2015 оноос суурь дамжаанд суралцаж, төгссөн оюутан мэргэжлээ сонгон орж ирдэг болсон байна.

- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

АШУҮИС-д шинээр элсэн орж байгаа оюутнуудад чиглүүлэх сургалтад хамруулдаг бөгөөд салбар сургуулиудын танилцуулга, мэдээлэл, гарын авлага, материалаар хангадаг байна. Хичээлийн шинэ жил эхлэхээс 7 хоногийн өмнө Харилцааны ур чадварын 1 багц сургалтад хамруулж, сургуулийн хичээлийн байр, номын сан, лаборатори зэрэгтэй танилцуулдаг байна. АШУҮИС-ийн оюутнуудад үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах, шинэ оюутнуудад ЕБС-ийн арга барилаас ИС-ийн сурах арга зүйн хэв маягт шилжих арга барилыг зааж зөвлөх, эрдэм шинжилгээ, хүмүүжлийн олон талт ажилд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, татан оролцуулах ажлыг зохион байгуулж байна. Суралцагч оюутнуудтай уулзаж ярилцахад тэдний сэтгэл ханамж маш сайн 100% байлаа.

Шинээр элсэн орсон оюутнуудыг эхний 2 жил ерөнхий эрдмийн хөтөлбөрөөр сургаж, 3-р курсээс нь мэргэжил сонгодог болгосон нь тэднийг ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход үр нөлөөгөө үзүүлэх арга хэмжээ болжээ.

Зөвлөмж:

1. 1-2 курсын оюутнуудыг мэргэжлээ зөв сонгоход туслах, чиглүүлэх үйл ажиллагаанд онцгой анхаарах, эм зүйч мэргэжлээ сурталчлах, элсэх оюутны тоо, сурлагын чанарт анхаарах,
2. Элсэн суралцагсдын амжилтыг хөхүүлэн дэмжих олон талт үйл ажиллагааг өргөжүүлэх,

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн

Оюутнуудад зөвлөх үйл ажиллагаа нь хүмүүжил, сургалтын үйл ажиллагаатай зэрэгцэн төлөвлөгөөний дагуу тасралтгүй зохион байгуулагддаг байна. 2011- 2015 онд оюутанд зөвлөх, тэднийг хөгжүүлэх үйл ажиллагааг сургалтын үйлчилгээ, урлаг соёл, хүмүүжлийн, спортын арга хэмжээ гэсэн 3 үндсэн чиглэлийг баримтлан, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.

- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт

2011- 2015 онд АШУҮИС-ийн оюутны алба нь оюутан элсэн орохоос төгсөх хүртэлх нийгмийн асуудлыг шийдэх үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Оюутнуудын сурч боловсрох нөхцөлийг сайжруулах, оюутанд үйлчлэх үйлчилгээнд оюутны 3 дотуур байр,

оюутнуудад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг Оюутны Эрүүл Мэндийн Төв, төв номын сан, спорт заал, Эко цогцолбор, интернет кафе зэргийн үйл ажиллагаа ордог. Орон нутгаас суралцаж байгаа оюутнууд Оюутны 1,2,3 байранд амьдарч, сурах боломжоор хангагддаг байна. /Улсад тэргүүлж, 2 удаа үзүүлэх сургууль зохион байгуулсан байна.\ Оюутны дотуур байрны хангамж харьцангуй сайн, сурч боловсрох нөхцөлөөр хангаж өгсөн байдгийг оюутнууд ярьж байлаа. Оюутны Эрүүл Мэндийн Төв оюутнуудынхаа эрүүл мэндийг хариуцан хамтран ажилладаг байна. Энэ төв нь орон нутгаас ирсэн харьяалалгүй оюутнуудыг үзлэг шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зэргээр үүдэн эмнэлгийн тусламж үзүүлдэг юм байна.

Зөвлөн туслах үйлчилгээний талаар оюутны сэтгэл ханамжийн судалгаа хийхэд 69,2% сэтгэл ханамжтай байжээ.

- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал

Элсэгчдэд зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн дагуу, лекц, танилцуулах үйл ажиллагаа төлөвлөсөн графикийн дагуу явагддаг. Сургалттай холбоотой олон төрлийн сонирхолтой ажиллагаа АСТ, семинар, оюутны клуб /ЭЗС дээр Адонис оюутны клуб идэвхитэй ажилладаг/, сургуулийн болон тэнхмүүдийн ойн эрдэм шинжилгээний хурал, ОУ-ын хурал, нийгэмлэг, анги дамжааны хурал, урлаг, спортын клубт суралцах, арга хэмжээнд оролцох зэрэг оюутнуудыг хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөтэй зохион байгуулж хэвшсэн байна.

Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн, эрүүл аж төрөх чиглэлээр яаж шилдэг оюутан болох вэ, мэргэжил бүхэн сайхан, хэрхэн үр дүнтэй суралцах вэ, мэргэжилтний үнэ цэнэ, алтан эгшиглэн зөвлөгөө, эмч мэргэжилтний үнэ цэнэ, цагаан халад- бидний гоёл аян, витаминжуулалт, дархлаажуулалтын аян, профессорын үнэ цэнэ цуврал лекц зэрэг арга хэмжээ зохион байгуулж, баримтжуулсан байна. ЭЗС-ийн ахмад багш нарыг хүлээн авч, оюутнуудтай хамтран 5 удаагийн уулзалт зохион байгуулжээ. Энэ үйл ажиллагааны талаар оюутнуудаас асуумжаар судалгаа авахад 96,5% нь амьдрах, суралцахад үр дүнтэй гэж дүгнэжээ.

- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал

ЭЗС-ийн багш, төгсөгчид Төв аймгийн Эрдэнэ суманд байдаг ургамал тарималжуулах талбайд чацаргана, хайлаасны 530 суулгац суулгажээ

Сургуулиа сурталчлах зорилгоор бусад их сургуулиуд дээр 2012, 2014 онд витаминжуулалтын аян, маргаашийн мэдлэг өнөөдрөөс аяны хүрээнд ЭЗС-ийн 1-4 курсын оюутнуудын санаачлагаар Эм зүйн сургуулийн номын сангийн шинэ фонд үүсгэж, нэг оюутан 2-оос доошгүй ном хандивласан байна.

Өөрчлөлтийг өөрөөсөө, Маргаашийн хандлага өнөөдрөөс, ирээдүйн амжилт хандлагаас г.м олон санаачилсан оюутнуудын ажлыг дэмжин шалгаруулж, урамшуулдаг байна.

- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал

АШУҮИС-ийн Оюутны холбоо, Оюутанд үйлчлэх төв, Залуучуудын Хөдөлмөрийн Төв Бирж хамтран "Цагийн ажил – өдөрлөг" зохион байгуулж, энэ өдөрлөгт ажил олгогчид, МОХ, олон нийтийн байгууллагууд оролцож хэвшсэн байна. ЭЗС 2011-2015 онд 5 удаагийн төгсөлт 245 мэргэжилтэн төгссөн бөгөөд төгсөх ангийн оюутнуудад зориулж, "Нээлттэй ажлын байрны

өдөрлөг” зохион байгуулдаг байна. Энэ өдөрлөгт ЭХНБ, Эмийн үйлдвэр, Эмийн сангийн байгууллагууд оролцож, санал бодлоо солилцож, мэргэжилтнээ сонгон авдаг байна.

- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусалсан байдал
ЭЗС-ийн оюутнууд эрдэм шинжилгээ, судалгааны орчин үеийн аргуудад суралцаж, ЭШС-ны ажлын сэдэв гаргаж, сэдэв сонгосон оюутныг тухайн чиглэлээр багш нар удирдан ажилладаг байна. Багш бүр өөрийн судалгааны чиглэлээр оюутны эрдэм шинжилгээний дугуйлан хичээллүүлж, эрдэм шинжилгээний ажлыг нь удирддаг байна. ЭЗС жил бүр оюутны дунд “Эрдмийн бага чуулган” АШУҮИС-ийн “Оюутны эрдмийн чуулган”-ыг зохион байгуулдаг байна. Мөн ЭЗС-ийн оюутнууд бусад их, дээд сургууль, нийгэмлэг, клубээс зохион байгуулж байгаа эрдэм шинжилгээний хуралд идэвхитэй оролцдог байна.

Зөвлөмж:

1. Оюутнуудын дунд нийгмийн эрүүл мэндийн ажлыг оновчтой зохион байгуулах, 4-5 курсын оюутнуудыг бусад их, дээд сургуулиудад сургалт сурталчилгаа хийлгэх үйл ажиллагаанд төлөвлөгөөтэйгөөр оролцуулах,
2. Оюутны эрдэм шинжилгээний судалгааг хөхүүлэн лэмжиж, оролцогсдын тоог нэмэгдүүлэх,
3. Оюутнуудын дотуур байрны хангамжийг сайжруулахад байнга анхаарах, тэдний сэтгэл ханамжийн байдлыг нэмэгдүүлэх,

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал

Тус сургуулийн оюутнуудын өөрөө удирдах дээд байгууллага нь АШУҮИС-ийн Оюутны холбоо юм байна. ЭЗС-ийн Оюутны нийгэмлэг 2001 онд байгуулагдсан, УЗ нь 12 хүний бүрэлдэхүүнтэй, дотроо баг, секцэд хуваагдан үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ хугацаанд 245 оюутныг эгнээндээ нэгтгэсэн байна. ЭЗСОН нь ЭЗС-ийн спортын бага наадам, “Шинэ жилийн” үдэшлэг, багш оюутны хавар, намрын аялал, АШУҮИС-иас зохион байгуулдаг урлаг, спортын арга хэмжээнд оюутнуудыг бэлдэж, уламжлал болгон оролцдог байна.

Тус сургуулийн дэргэд 2007 оноос хойш Эм зүйн оюутны “Адонис” клуб ажиллаж, оюутнуудын нийгмийн идэвхийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд татан оролцуулахад анхаарч байна. Одоо 39 гишүүнтэй. Клубын гишүүдийн төлөөлөлтэй уулзаж, ярилцахад клубээс зохион байгуулагддаг ажил, сургуулийн дэмжлэгт сэтгэл ханамжтай байлаа. Мөн зуны сургалтын хүрээнд БНХАУ, ОХУ-ын оюутнуудтай хамтран ажиллаж, туршлагаа солилцдог байна.

- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал

Сургуулиас оюутны байгууллагаас зохион байгуулдаг олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна. Ямар үйл ажиллагаанд хэдэн төгрөг зарцуулснаа тооцсон санхүүгийн тайлангаа гаргасан байна. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байгаа нь тайлангаас харагдаж байна. ЭЗС-ийн оюутанд үзүүлэх үндсэн үйлчилгээ нь сургуулийн чиг үүрэг, бүрэн эрх, санхүүжилт, ажиллах нөхцөл, оюутан дадлага хийх, хөдөлмөр эрхлэхэд туслах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх зэрэг зохион байгуулалтын хүрээнд үйлчилж байна. Сургуулийн зүгээс оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг сайн, зохион байгуулж байгаа үйл ажиллагааг бүх талаар дэмждэг болохыг нотлох баримтаар, оюутнуудын төлөөлөлтэй ярилцах аргаар дүгнэлээ.

- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Оюутны байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагааны санхүүгийн тайланг ил тод тайлагнадаг, мэдээлдэг байна. Эм зүйч бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг, хандивыг хувийн хэвшлийн Эм хангамжийн байгууллага, ОУБ-ын төсөл, гадаад хамтын ажиллагаатай байгууллагаас авдаг байна. Сурлагын өндөр амжилт гаргасан, ар гэрийн гачигдалтай оюутнуудад үзүүлж буй санхүүгийн хөнгөлөлт, дэмжлэгийг сайшаан дэмжих хэрэгтэй байна. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг авах ажилд ажил олгогчдыг татан оролцуулж, тэдний дэмжлэгийг авч чадсан байна. Судалгаанаас харахад 10 гаруй тэтгэлэгт хөтөлбөрт 30 гаруй оюутныг хамруулсан байна.

Зөвлөмж:

1. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагддаг оюутнуудын тоог нэмэгдүүлэх. Ялангуяа гадаадад оюутан солилцоогоор суралцуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх,
2. Гадаадын оюутны Сайн дурын байгууллагатай хамтран ажиллах талаар ОБ-ыг чиглүүлэх

4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

ЭЗС-ийн оюутнууд 2011-2015 оны хичээлийн жилд тэтгэлэг, урамшуулалд хамрагдсан судалгаанаас харахад нийт 31 оюутан БНСУ-ын Ионсейн ИС, Голомт банк, МЭИК-ДОНГ-А СОШИА группын нэрэмжит сургалтын тэтгэлэг, зэрэг 10 гаруй тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.

- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд

2011- 2015 онд МЗХ, МАСОХ, МОХ зэрэг оюутан, залуучуудын байгууллага, АШУҮИС-ийн оюутны дээд шагнал зэрэг 17 төрлийн шагналуудаар шилдэг оюутнуудаа шагнасан байна.

- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

2014-2015 оны хичээлийн жилд ЭЗС-ийн сургалтын тэтгэлэгт сурлага, урлаг спорт, эрдэм шинжилгээний ажилд манлайлагч 6 оюутныг 3,9 сая₮-ний тэтгэлэгт хамруулан урамшуулжээ. Урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд зарцуулсан төсвийн тайлангууд байлаа.

Зөвлөмж:

1. Оюутнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, суралцах боломжоор нь хангах,
2. Ажил олгогч нартай гэрээ байгуулан, оюутнуудыг Тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх,

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал

Оюутны шилжилт хөдөлгөөнийг АШУҮИС-ийн захирлын 2015 оны тушаалаар батлагдсан Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу шийдвэрлэдэг. Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх зэргээр холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж хэвшсэн байна.

- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт

ЭЗС-ийн оюутнуудын 2011-2015 оны хичээлийн жилийн шилжилт хөдөлгөөний судалгаанаас харахад нийт 79 оюутан шилжилт хөдөлгөөн хийжээ. Судалгаанаас харахад гадаад, дотоодын сургуулиас шилжин ирсэн оюутны тоо өссөн, өөр сургуульд шилжсэн оюутны тоо цөөн байна. Хувиар тооцвол, шилжиж ирсэн нь 79,2%-иар их байна. Шилжилт, хөдөлгөөний судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлттэй ажилладаг юм байна.

- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Анги удирдсан багш нар голч дүнгээс бага дүнтэй оюутантай тулж ажиллан, доголдож байгаа хичээлээ хэрхэн нөхөх талаар зөвлөдөг. Шилжиж ирсэн оюутны хичээлийн зөрүүг АШУҮИС-ийн оюутны алба гаргадаг. ЭЗС-ийн захиргаа тухайн шилжиж ирсэн оюутныг нөхөж суралцах нөхцөлөөр хангаж, багшийг томилдог байна. Шилжин ирсэн оюутнуудыг зөрүүтэй хичээлээ нөхөж суралцах боломжоор бүрэн хангадаг байна.

Зөвлөмж:

Батлагдсан дүрэм, журмын дагуу үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой гэж үзлээ.

Шалгуур 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Эм зүйн сургууль нь багшлах боловсон хүчнийг тодорхой шалгуурын дагуу сонгон шалгаруулж ажилд авдаг уламжлалтай байгаа бөгөөд шинэ багш нар цаашид мэргэжлийн болон багшлах тал дээр хөгжих, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх асуудалд төлөвлөгөөтэй ажиллаж байна.
 - Дээд боловсролын тухай хуульд заасанчлан тус сургуулийн багш нар 100% магистр түүнээс дээш зэрэг, цолтой байна.
 - Багш оюутны зохистой харьцаа АШУҮИС-ийн тавьж буй зорилтот хүрч байна.
 - Багш нарыг албан тушаалын зэрэглэлийг албан тушаалын ангилалд тавигдах шаардлагын дагуу тогтоож байна.
 - Багш нарыг урамшуулах тогтолцоотой байна.
- **Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт**

Багшийн цагийн ачаалалд үндэслэн шаардлагатай магистр болон түүнээс дээш зэрэг цолтой, эм зүйн салбарт 3 түүнээс дээш жил ажилласан туршлагатай мэргэжилтнийг АШУҮИС-ийн захирлын 2016 оны А/118 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”-дагуу сонгон шалгаруулж хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилладаг байна. Тайлант хугацаанд 8 багшийг зохих журмын дагуу сонгон шалгаруулж авсан байна. Шинээр ажилд орсон багш нарын сурган заах арга зүй, багшлах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Багшийн хөгжил төв”-өөс зохион байгуулдаг сургалт семинарт хамруулах, туршлагатай багш нарын хичээлд суулгах ажлууд тогтмол зохион байгуулагдсан байна.

- **Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин**

Эмч зүйч бэлтгэх хөөлбөр хэрэгжүүлэгч нийт багш нарын 41 (57,7%) нь докторын зэрэгтэй, үүнээс 14 (34,1%) нь ЭЗШУ-ны болон ЭЗУ-ны доктор, 27 (65,8%) нь АУ-ны, техникийн ухааны, химийн ухааны, эдийн засгийн ухааны доктор байна. Эм зүйн салбарын нийт багш нарын 15 (57,7%) ЭЗШУ-ны болон ЭЗУ-ны доктор, АУ-ны докторын зэрэгтэй байна. 2011-2016 онд эм зүйн салбарын 4 багш докторын зэрэг, 7 багш магистрын зэрэг хамгаалсан байна.

- **Багш суралцагчдын тооны зохистой харьцаа**

АШУҮИС багш оюутантай нягт хамтран ажиллах бололцоог бүрдүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор багш, сурцагчдийн харилцааг 1: 12 хүртэл бууруулах төлөвлөгөөтэй байна. Эм зүйн сургуулийн I-IV дамжаанд нийт 311 оюутан суралцаж байгаа бөгөөд нэг багшид дунджаар 11,9 оюутан оногдож байна.

- **Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал**

Эм зүйн салбарт 2016-2017 оны хичээлийн жилд нийт 26 багш ажиллаж байна. Эм зүйн бакалаврын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 75 багшаас профессор 4/5,1%, дэд профессор 16/20,3%, ахлах багш 24 /30,4%, тэнхимийн багш 25 /31,6%, дадлагжигч багш 6/7,6%, цагийн багш 4/5,1% байна. 2016-2017 оны хичээлийн жилд ажиллаж буй эм зүйн салбарын багш нарын албан тушаалын зэрэглэлийг 2010-2011 оны хичээлийн жилтэй харьцуулахад профессорын тоо 3,1%-иар, ахлах багшийн тоо 31,2%-иар буурч харин дэд профессор 9,6%-иар, багш 7,3%-иар, дадлагжигч багш 17,3%-иар тус тус өссөн байна.

- **Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал**
АШУҮИС-ийн шилдэг багш шалгаруулах журамын дагуу сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажиллаараа шалгарсан багш нараа тухайн хичээлийн жилд урамшуулдаг байна. 2015-2016 оны хичээлийн жилд Эмийн хими, ургамал судлал, Эмийн технологийн тэнхим АШУҮИС-ийн тэргүүний тэнхимээр шалгарсан байна. АШУҮИС-ийн захиралын 2016 оны А-109 тоот тушаалаар “Багшийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой урамшуулалын

үнэлгээ” –нд Томсон Ройтерсийн индекс бүхий олон улсын сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн үндсэн багш, ажилтанд урамшуулал олгодог нь багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажлыг идэвхижүүлэх, багш нарыг урамшуулах таатай зохицуулалт болж байна. Багшийн мэргэжил заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшинг дээшлүүлэхэд сургуулийн захиргаанаас тодорхой дэмжлэгүүдийг үзүүлдэг байна. Үүнд:

- Гадаадын их дээд сургуультай хамтарсан гэрээг ашиглан мэргэжилээ дээшлүүлэх, магистрантур, докторантурын сургалтанд хамруулах
- Хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсанаар гадаад их дээд сургуулийн багш нарын судалгааны ажлын түвшинтэй танилцах, хамтарсан судалгаа хийх, туршлага солилцох
- Улсын болон олон улсын төсөл хөтөлбөр гэрээт ажлын удирдагч, гүйцэтгэгчээр оролцох
- Заах арга зүйн ур чадвараа дээшлүүлэх сургалтанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх
- Шинээр ажилд орсон дадлагжигч багш нарт цагийн ачаалалын хөнгөлөлтийг эхний жилд үзүүлэх

Эм зүйн сургууль нь багшлах боловсон хүчнийг тодорхой шалгуурын дагуу сонгон шалгаруулж ажилд авдаг уламжлалтай байгаа бөгөөд шинэ багш нар цаашид мэргэжлийн болон багшлах тал дээр хөгжих, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх асуудалд төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дээд боловсролын тухай хуульд заасанчлан тус сургуулийн багш нар 100% магистр түүнээс дээш зэрэг, цолтой байна.

Багш оюутны зохистой харьцаа АШУҮИС-ийн тавьж буй зорилтот хүрч байна.

Багш нарыг албан тушаалын зэрэглэлийг албан тушаалын ангилалд тавигдах шаардлагын дагуу тогтоож байна.

Багш нарыг урамшуулах тогтолцоотой.

Зөвлөмж:

1. “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /ROADMAP/ 2010-2021”аар их сургуулийн багш, судлаачдын 50-аас доошгүй хувийг докторын зэрэгтэй болгож чадавхийг дээшлүүлэх зорилтыгтавьсны дагуу докторын зэрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэх
2. Багш нарын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх

5.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшинг тусгайлан боловсруулсан санал асуулгын хуудсаар асуумж судалгаа авч үнэлгээ дүгнэлт хийж ажиллаж байна.
- Багш хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу багш нар мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх гадаадын болон дотоодын сургалтанд хамрагдаж байна.

- **Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал**

Эм зүйч мэргэжлээр сурч буй оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг байна. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 91,9% нь тус сургуулийн сургалтын хөтөлбөрт сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна. Дадлага хичээлийг илүүтэй оруулах, үйлдвэр болон эмнэлэг дээр дагалдах хугацааг уртасгахыг оюутнууд илэрхийлсэн байна. Төгсөгчдөөс авсан сэтгэл ханамжийн судалгаанд 96,5% нь мэдлэг, чадвар хангалттай 89,6% нь дунд зэрэг гэж хариулсан байна. 28 эм хангамжийн байгууллагуудын удирдах ажилтныг хамруулсан ажил олгогчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад төгсөгчдийн мэдлэгийг хангалттай 7,14%, боломжийн 82,1% гэж үнэлсэн байна. Эм зүйчдийн эзэмшсэн ур чадварыг 74,1% нь боломжийн гэж үнэлсэн байна. Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн удирдан манлайлах, зохион байгуулах чадвар хангалттай гэж 17,8%, боломжийн гэж 53,5% нь үзсэн байна. Түүнчлэн суралцагчид, төгсөгчид, ажил олгогчидтой хийсэн уулзалтаар багш нарын заах арга зүйг хангалттай хэмээн тодорхойлж байлаа.

Судлаач Ц.Ариунтуяа “Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн үнэлгээ” сэдэвт судалгааны ажил хийж хөтөлбөрийн хэрэгжилтэнд нотолгоонд суурилсан дүгнэлтийг гаргажээ.

- **Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт**

“АШИҮУС-ын хөгжил” бол “Багшийн хөгжил” гэж тодорхойлсны дагуу багшийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэн ажилладаг байна. Багшийн хөгжил төвөөс зохион байгуулдаг сургалтанд эмзүйн сургуулийн багш нар 100% хамрагджээ. 2011-2016 онд мэргэжлийн чиглэлээр дотоодод 11 багш гадаадад 31 багш сургалтанд хамрагдаж мэргэжлээ дээшлүүлсэн байна.

- **Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал**

Багшийг хөгжүүлэх урт, богино хугацааны төлөвлөгөө мэргэжлийн, эрдэм шинжилгээ, судалгааны болон анагаах ухааны боловсролыг дээшлүүлэх сургалтанд хамруулж байна.

2011-2016 онд анагаах ухааны боловсрол судлалын сургалтанд эмзүйн салбарт ажилд шинээр орсон 6 багш хамрагдаж амжилттай суралцсан байна.

2015 онд АШИҮУС-ийн нийт багш нарт зориулсан “HINARI” сэдэвт цуврал семинар сургалт зохион байгуулагдаж эмзүйн сургуулийн 14 багш оролцож эрдэм судалгаа шинжилгээний ажилд хайлтын системийг хэрхэн ашиглах талаар мэдлэг, чадвар эзэмшжээ.

- **Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал.**

Эмзүйн сургууль нь Ази, Европын зарим орнуудын эмзүйн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг судалж, гадаадын 5-н орны 12 их дээд сургуулиудтай хамтран ажиллаж байна. 2014 онд Австрали болон БНХАУ-д эмзүйн ухааны доктор зэргийг 2 багш хамгаалсан байна. Одоогийн байдлаар 5 багш Голланд, Герман, Япон, БНХАУ болон дотооддоо эм зүйн ухааны докторын зэрэг хамгаалахаар суралцаж байна. Гадаад зохион байгуулагдсан сургалт, семинар, эрдэм шинжилгээний хуралд давхардсан тоогоор 15 багш оролцсон байна.

Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшинг тусгайлан боловсруулсан санал асуулгын хуудсаар асуумж судалгаа авч үнэлгээ дүгнэлт хийж ажиллаж байна.

Багш хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу багш нар мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх гадаадын болон дотоодын сургалтанд хамрагдаж байна.

Зөвлөмж:

1. Сургалтын чанарт ахиц гаргах, төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага, удирдан манлайлах, зохион байгуулах ур чадварыг дээшлүүлэх тал дээр шинэлэг ажлуудыг зохион байгуулах, сургалтын агуулгад тусгаж өгөх

2. Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд тавих, Томсон Ройтерсийн индекс бүхий олон улсын сэтгүүлд нийтлүүлэх чансаа өндөртэй илтгэл, өгүүлэлийн тоог нэмэгдүүлэх, хэвлүүлэх

5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- АШУҮИС-н харъяа “Эрдэмфарм” эмийн үйлдвэрийг ажиллуулж эхэлсэн нь сургалтыг үйлдвэрлэлд ойртуулах томоохон алхам болж чадсан байна.
- Эм зүйн салбарын төсөлт ажлын удирдагч болон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
- Эм зүйн багш нарын эрдэм судалгааны ажлын үр дүнгээс бусад судлаачид ишлэл авч ашигласан байна.

- *Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, патентийн тоо*

2013-2015 онд “Тамиржуулагч шинэ эмийн бэлдмэлийн технолгийг үйлдвэрлэд нэвтрүүлэх инновацийн төсөл”-ийг хэрэгжүүлж, АШУҮИС-н харъяа “Эрдэмфарм” эмийн үйлдвэрийг ажиллуулж байна. Бидний ажиллах хугацаанд үйлдвэр түр хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоосон байлаа.

- *Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал*

Эм зүйн салбарын багш нар 2011-2016 онд давхардсан тоогоор 37 төсөлд удирдагч болон гүйцэтгэгчээр ажилласан байна. Тухайлбал: 2011 онд 11 төсөл, 2012 онд 11 төсөл, 2013 онд 6 төсөл, 2015 онд 7 төсөл тус тус хэрэгжүүлсэн байна.

- *Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй, судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал*

Эм зүйн салбарын багш нар эмийн технологи, эмийн хими, эмийн ургамал судлал, эмнэл зүйн эм зүй зэрэг чиглэлээр төсөл хөтөлбөр, гэрээт болон захиалгат ажлыг гүйцэтгэж байна. МУ-н хүний эмийн зөвлөлийн гишүүн 2, ЭМЯ-ны Эм зүй, Эм судлал мэргэжлийн зөвлөлийн даргаар 1, Эм зүй, эм судлалын ерөнхий мэргэжилтэн, ЭМЯ-ны фармакопейн хорооны гишүүн, Эм холбооны удирдах зөвлөлийн гишүүн 1, СХЗҮХ-ны техникийн хорооны гишүүн 1, GMP-ийн шинжээчээр 2, ЭМСЯ-ны хүний эмийн фармакопейн хорооны эм зүйн салбар зөвлөлийн гишүүнээр 4 хүн тус тус ажиллаж байна. ЭМЯ болон Эм зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд багш нар ажилласнаар МУ-н эм зүйн салбарын өнөөгийн байдал хэтийн төлөвийг үнэлэн эм зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийхэд ихээхэн дөхөм болж байна.

- *Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал*

Эм зүйн сургуулийн багш нарын эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл 2011-2016 онд гадаадын, дотоодын сэтгүүлд 130-г хэвлүүлжээ. Олон улсын эрдэм шинжилгээний хуралд 59, үндэсний чанартай эрдэм шинжилгээний хуралд 196 нийт 255 илтгэл хэлэлцүүлсэн байна. Олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хэвлэгдсэн судалгааны ажлаас 113 удаа ишлэгсэн байна. 2015 онд хэвлэгдсэн илтгэл, өгүүлэлийн тоо 2011 онтой харьцуулахад 2,1 дахин өссөн байна.

АШУҮИС-н харъяа “Эрдэмфарм” эмийн үйлдвэрийг ажиллуулж эхэлсэн нь сургалтыг үйлдвэрлэлд ойртуулах томоохон алхам болж чадсан байна.

Эм зүйн салбарын төсөлт ажлын удирдагч болон гүйцэтгэгчээр ажиллаж байна.

Эм зүйн багш нарын эрдэм судалгааны ажлын үр дүнгээс бусад судлаачид ишлэл авч ашигласан байна.

Зөвлөмж:

1. АШУҮИС-н харъяа “Эрдэмфарм” эмийн үйлдвэрийн байнгын үйл ажиллагааг хангах
2. Үйлдвэрлэлд нэвтрүүлэх шинэ технологи, бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх, чанарын баталгааг хангах

5.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Багшийн хавтсанд байх шаардлагатай материалуудын жагсаалтын дагуу багш нар хавтасаа бэлтгэсэн, нотлох баримттай цэгцтэй байна.
- Багш нар 100% багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

- **Өөрийн үнэлгээний тайлан**

Багш бүр улирлын эхэнд ажлын төлөвлөгөөгөө тэнхимийн эрхлэгчээр батлуулан ажиллаж, ажлын гүйцэтгэлийн тайлангаа улирлын төгсгөлд бичдэг байна. Батлагдсан загварын дагуу өөрийн үнэлгээний тайланг бичиж СБЗГ-ын харьяа “Багшийн хөгжлийн зөвлөл”-д хүргүүлдэг байна. Эмзүйн сургуулийн Ц.Ариунтуяа, Сүрэнмандах, Отгонсүрэн, Энхтуул, Пэрлэйдулам нарын дадлагажигч багш нартай нэг бүрчлэн ярилцаж багшийн хавтастай танилцлаа. Багш нарын хийсэн ажилдаа дүгнэлттэй, цаашид хийх ажлаа төлөвлөдөг нь өөрийн үнэлгээ тайлангаас харагдаж байлаа.

- **Багшийн хөндлөнгийн үнэлгээ / аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/**

Эм зүйн салбарын 13 багш аттестатчлалд орж, 79-98,9%-тай үнэлэгдсэн ба үүнээс 12 (92,3%) ажлын гүйцэтгэл, үр дүн сайн 1 дадлагажигч багш дунд зэрэг гэж үнэлэгдсэн байна. Үлгэрчилсэн асуулгын хуудсаар оюутнуудаас санал авч, багшийн ажлг хөндлөнгөөс үнэлэж байна.

- **Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа**

Багш нарын заах арга зүйг 3,89 буюу дунджаас дээгүүр гэж 2014-2015 оны хичээлийн жилд үнэлсэн байна. 2015-2016 онд авсан судалгаагаар судалгаанд хамрагдсан оюутнуудын 56% багш нарын заах арга зүй маш сайн, 46% сайн гэж үнэлсэн байна. Багш нар хичээлийн төгсгөлд оюутнуудаас асуумж судалгаа авч, өөрийн заах арга зүй, ур чадвартаа дүгнэлт хийж цаашидсайжруулах талаар дээр анхааран ажиллаж байна.

- **Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал**

Амжилттай аттестатчлагдсан багш нарт багшлах эрхийн гэрчилгээ олгодог бөгөөд тэд мэргэжлийн мэдлэг, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ судалгааны ажилдаа ахиц гаргах төлөвлөгөөтэй ажилладаг байна.

- **Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх**

Төгсөлтийн өмнөх сургалтын албанаас боловсруулсан үлгэрчилсэн асуулгын хуудсаар оюутнуудаас санал авдаг байна. Сургалтын үнэлгээний 10 оноог бүрдүүлэхээс эм зүйн салбарын багш нар 7,9-9,9 оноо авсан дүн судалгаанаас ажиглагдаж байна.

- **Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал**

Аттестатчилалын шалгуур үнэлгээний дагуу багш нар сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн ангиллаар өөрсдийн ажлын тайланг бэлтгэдэг байна. Эм зүйн салбарын багш нарын хавтастай танилцахад тэдний хийсэн бүхий л үйл ажиллагаа сургуулийн зүгээс тавьж буй шаардлагыг хангаж байгаа нь сайшаалтай байлаа.

Багшийн хавтсанд байх шаардлагатай материалуудын жагсаалтын дагуу багш нар хавтасаа бэлтгэсэн, нотлох баримттай цэгцтэй байна.

Багш нар 100% багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

Зөвлөмж:

1. Лекцийн хичээлийн сэдэв тус бүрээр агуулгын хувьд нэгдсэн сан бий болгож, багш бүр өөрийн хавтаст багтаан ашигладаг байх
2. Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээнд хийсэн дүгнэлтийн дагуу хийх ажлын төлөвлөгөө гаргах, биелэлтийг тооцож ажиллах
3. Оюутны идэвхийг сэргээсэн, сэдвийн онцлогт тохирсон, шинэлэг аргуудыг сургалтанд нэвтрүүлэх

5-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Сонгон суралцах хичээлүүд зөвхөн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан байна.
- Онолын мэдлэгийг бататгах дадлагыг эмнэлэг, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, лаборатори зэрэг эрүүл мэндийн байгууллагууд дээр зохион байгуулж байна.
- Эмнэл зүйн эм зүйч бэлтгэх хөтөлбөрт эмнэл зүйн хичээлүүдийн 20% орчим нэмэгдэж орж байна.

- **Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ**

АШУҮИС-ийн ЭЗС нь Монголын Эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбоотой хамтран АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, эм зүйч мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтонд нийцсэн “Эм зүйч” мэргэжилтэн бэлтгэх “+3 сургалтын хөтөлбөр”-ийг ажил олгогч нартай зөвлөлдөн боловсруулсан байна.

Эм зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрт эмийн чанарын хяналт, чанарын удирдлагын тогтолцоо, эмнэл зүйн хичээлүүдийг оруулсан нь ач холбогдолтой хэмээн ажил олгогчид, төгсөгчдын төлөөлөл илэрхийлж байна.

- ***Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал***

АШУҮИС-ийг эм зүйч мэргэжлээр төгсөгч нь харилцагч, хамтрагч, зохион байгуулагч, зөвлөгч, тасралтгүй суралцагч, мэргэжилтэн байж эм зүйн тусламж үзүүлэгч байна гэж томъёолсон байна.

Цогц чадамжийг эзэмшүүлэхдээ уялдуулан, оюутны практик үйл ажиллагааг үр бүтээлтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалтын аргуудыг сургалтандаа хэрэгжүүлж эхэлсэн байна. Сургалтын агуулгыг хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдлыг шинжлэх нэгээхэн том шалгуур нь төгсөгчдийн шалгалтын үнэлгээ бөгөөд эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагыг 2016 оны байдлаар харуулбал; онолын шалгалтын чанар 90%, амжилт 100% байна. Харин гардан шалгалтын чанар 81%, амжилт нь 100% байна.

- ***Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал***

Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын төлөвлөгөөнд 173 багц цаг байна. Үүнээс сонгон судлах 15 хичээл, 10 багц цагийн хичээл судлах боломжтой боловч багшийг сонгон суралцах боломжгүй.

- ***Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал***

Өдгөө мөрдөж буй хөтөлбөр нь онолын хичээлийг практиктай хослуулах, үйлдвэрлэлийн дадлагаар бататгах, ур чадвар эзэмшүүлэх шугаман сургалт, эм зүйчийн өдөр тутамд гүйцэтгэх ажлын мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэх сургалтаас бүрдэж байна. Суралцагчдын хувьд танхимийн сургалт зонхилж байна. Суралцагчид сургуулийн эмийн санд багшийн удирдлага дор ажиллаж онолын мэдлэгээ практик үйл ажиллагаатай холбож байна.

- ***Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал***

Эмийн чанарын баталгаажилт, эмийн үйлдвэрийн технологи зэрэг зарим мэргэшүүлэх хичээлийн дадлагыг ЭЗБАС-ийн эм шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатори, “Эрдэм фарм” эмийн сан, “Сударын тун”, “Тавин ус”, “Нахиа”, “Мөнхийн тун” зэрэг эмийн үйлдвэрүүдэд дээр явуулж байна. Эмнэл зүйн эм зүй, Эм зүйн албаны зохион байгуулалтын дадлагын хичээлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ зэрэг эрүүл мэндийн байгууллага дээр зохион байгуулж байна. 2012-2016 онд 590 оюутан 11 байгуулагад дадлага хийсэн байна.

- ***Зайны болон цахим хичээлүүдийг E-контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал***

Анагаах ухааны төв номын санд цахим ном 4258, мультимедиа 9805, Эрдмийн бүтээл 1095, цахим лекц 296, цахим сэтгүүл 3 байна. Оюутнууд сонгон суралцах хичээлийн лекцийг цахим хэлбэрээр судлаж байна.

- ***Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал***

Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд нь босоо ба хэвтээ тэнхлэгээр уялдан хэрэгжиж байна. 1-р дамжаанд шинжлэх ухааны ерөнхий суурь хичээлүүд, 2,3-р дамжаанд мэргэжлийн суурь хичээлүүд голчлон, 4,5-р дамжаанд мэргэшүүлэх хичээлийг судлаж байгаа бөгөөд төгсөөд ажиллах ажлын байрны шаардлагыг хангах үүднээс хичээл хоорондын уялдааг сайжруулах чиглэлд анхааран ажиллаж байна. Сонгон суралцах хичээлүүд зөвхөн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан байна.

Онолын мэдлэгийг бататгах дадлагыг эмнэлэг, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, лаборатори зэрэг эрүүл мэндийн байгууллагууд дээр зохион байгуулж байна.

Эмнэл зүйн эм зүйч бэлтгэх хөтөлбөрт эмнэл зүйн хичээлүүдийн 20% орчим нэмэгдэж орж байна.

Зөвлөмж:

1. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан сонгон суралцах хичээлүүдийг судлах бодит нөхцөлийг хангах, үнэлэх аргыг тодорхойлох
2. Дадлага хийсэн байгууллагаас суралцагчдийн мэдлэг, чадвар, хандлагын талаар дүгнэлт хийж болохуйц асуулт бүхий хуудсаар санал авч, цаашид сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тусгаж ажиллах
3. Дадлага хийх байгууллагын онцлогт тохирсон үйлдвэрлэлийн дадлагын удирдамж боловсруулах /тухайлбал; эмнэлгийн эмийн сан, эмийн үйлдвэр, лаборатори, ЭХНБ-д гэх мэт/ дадлагын үр өгөөжийг дээшлүүлэх
4. Төгсөгчид эмнэлгийн эм зүйн алба/тасагт төдийгүй эмийн үйлдвэр, лабораторит ажиллах тул мэргэшүүлэх хичээлийн зохистой харьцаанд дүн шижилгээ хийх

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- АШУҮИС-ийн төв сангаас гадна өөрийн сургууль дээр номын санг ажиллуулж байна.
- Оюутан төвтэй, асуудал шийдвэрлэх аргыг сургалтанд нэвтрүүлж байна.
- Бие даалтын хичээлийг үр өгөөжтэй болгох тал дээр Эм зүйн сургууль анхааран ажиллаж байна.

- *Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар*

Эм зүйч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг “SPICES” загвар, PBL, интерактив лекц зохион байгуулах байдлаар мөрдөж байна. +3 сургалтын хөтөлбөр алсдаа АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн дипломыг дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад хүлээн зөвшөөрөгдөхөд чиглэгдэж байна.

- *Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал*

Сургалтыг асуудалд суурилсан оюутан төвтэй хөтөлбөрөөр явуулж байна, оюутны бие даалтыг дэмжих асуудалд сургууль болон багш нар ихээхэн анхааран ажиллаж байна.

- *Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа*

Хөтөлбөрийн агуулгад нийцсэн 61 төрлийн 686 ширхэг ном сурах бичиг, 1500 гаруй ургамлын хатаамал, 200 шахам эмт бодис, эмийн ургамлыг сургалтанд ашиглаж байна.

Эм зүйн сургуульд эмийн шинжилгээний лаборатори, эмийн ургамлын лаборатори, эмийн технологийн лаборатори, эмийн үйлдвэр, эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт хийн хроматографи, спектрофотометр, вакуум уршуулагч аппарат, рефрактометр, микроскопи, хатуу, шингэн, зөөлөн эмийн хэлбэр бэлтгэх технологийн машинууд, шахмал,

капсул, нунтаг эм үйлдвэрдэх тоног төхөөрөмжийн иж бүрдэлүүд хэвийн үйл ажиллагаатай ажиллаж байна.

- **Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал**

Сургалтын арга зүй хэрхэн явагдаж байгаа талаар оюутнуудаас санал асуулга авахад, оюутнуудын дийлэнх нь сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн байна. Залуу багш нар профессор багшийн хичээлд суух, асуудалд шийдвэрлэсэн сургалтыг зохион байгуулах, багш нарын заах арга зүйг дээшлүүлэх чиглэлээр их сургуулиас зохион байгуулж буй сургалтуудад эм зүйн сургуулийн багш нар сайтар хамрагдаж байна. Тайлант хугацаанд 1 багш дунджаар 5-6 сургалтанд хамрагдсан байна.

АШУҮИС-ийн төв сангаас гадна өөрийн сургууль дээр номын санг ажиллуулж байна. Оюутан төвтэй, асуудал шийдвэрлэх аргыг сургалтанд нэвтрүүлж байна. Бие даалтын хичээлийг үр өгөөжтэй болгох тал дээр Эм зүйн сургууль анхааран ажиллаж байна.

Зөвлөмж:

1. Номын сангийн ашиглалтыг сайжруулах, суралцагчдын ном унших, номын сангаар үйлчлүүлэх соёлыг дээшлүүлэх үүднээс номын сангаар олон удаа үйлчлүүлсэн суралцагчийг тодруулдаг байх
2. Асуудал шийдвэрлэх тохиолдлыг ашиглах сэдвүүдийг тодорхой болгох, зөвхөн мэргэжлийн үүднээс төдийгүй холбогдох журам, хууль, хэрэглэгчтэй хэрхэн холбогдох тал дээр асуудлыг хөндөж тохиолдол боловсруулан сургалтанд ашиглах
3. Сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд бие даалтаар судлах хичээлийн сэдвүүдийг тодорхойлж оюутны зайлшгүй унших, ашиглах мэдээлэлийн эх сурвалжийн жагсаалт, эзэмших ур чадвар, гүйцэтгэх үйлдэл, гүйцэтгэлийг тооцох хэлбэр хугацааг тодорхойлох

6.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэндүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Тестийн нэгдсэн сантай бөгөөд үнэн магадтай байдалд дүн шинжилгээ хийлгэсэн байна.
- Шалгалтын аман шалгалт, тест, OSCE, эссэ бичих зэрэг олон хэлбэрүүдийг сургалтын үнэлгээнд ашиглаж байна.

- **Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ**

Эм зүйг сургууль шалгалтыг тест, эссэ бичих, OSCE хэлбэрээр авч байна. Тестийн нэгдсэн сантай байна.

- **Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал**

АШУҮИС-н оюутны үнэлгээний журмыг мөрдөн оюутны мэдлэг чадвар хандлагыг А,В,С,D, Fгэсэн үсгэн процент нь дүнгээр үнэлж байна. Оюутны шалгалтын дүн 60 ба түүнээс дээш тохиолдолд тухайн хичээлд тэнцсэнд тооцож байна. Оюутны шалгалтын дүнг холбогдох журмын дагуу их сургуулийн удирдлага, мэдээлэлийн системд оруулдаг байна.

- **Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал**

Анги удирдсан багш, оюутан бүр сурлагын дүнгээ UNIMIS программаас мэдэх бүрэн боломжтой юм байна.

- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

2016 оны төгсөгчдийн 5 жилийн мэдлэгийн үнэлгээг үнэлэн дүгнэхэд ерөнхий суурь хичээлийн үнэлгээний дундаж 76,4%, мэргэжлийн суурь хичээлийн үнэлгээний дундаж 75,6%, мэргэшүүлэх хичээлийн дундаж 82,3% байна. Төгсөгчид магадлан итгэмжлэгдсэн улсын болон хувийн хэвшлийн эмийн сан, эмийн үйлдвэр, эмнэлэгүүдэд ажил эрхэлж, төгсөгчдийн ажил эрхлэлт 99,58%-тай байна.

Тестийн нэгдсэн сантай бөгөөд үнэн магадтай байдалд дүн шинжилгээ хийлгэсэн байна.

Шалгалтын аман шалгалт, тест, OSCE, эссэ бичих зэрэг олон хэлбэрүүдийг сургалтын үнэлгээнд ашиглаж байна.

Зөвлөмж:

1. Суралцагч цээжлэх, тест бөглөж шалгуулахаас илүүтэй ойлгосон эсэх, мэдлэгээ цаашид практикт хэрэглэх асуудалд анхаарч тестийн нэгдсэн сангийн эргэн санах, уялдуулах сэтгэх, шалтгаан хамааруулах байдалд дүн шинжилгээ хийх
2. Шалгалтын хэлбэр нь тухайн хичээлийн, сэдвийн онцлогтой тохирч байгаа байдалд үнэлгээ хийх

6-р шалгуурын нэгдсэн үнэлгээ:

Шалгуур 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Ажил олгогчид, төгсөгчид сургуульд сэтгэл ханамжтай байгаа хэдий ч төгсөгчдийн төлөвшил, ёс зүйн асуудалд анхаарах нь ихээхэн чухал байгааг онцолж байна.
- Төгсөөд ажилд орох хүртэлх хугацаа харьцангуй богино байна.

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал

АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийг төгсөгчид эмнэлгийн эм зүйн алба, эмийн сан, эмийн үйлдвэр, лаборатори, ЭХНБ зэрэг байгууллагуудад ажиллаж байна. Тухайлбал: 2011-2015 оны байдлаар их, дээд сургуульд 5, эрдэм шинжилгээний байгууллагад 6, төрийн байгууллагад 12 төгсөгч ажиллаж байгаа бөгөөд 16 хүн үргэлжлүүлэн суралцаж байна.

- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа

9 асуулт бүхий санал асуулгын хуудсаар 28 эм хангамжийн байгууллагын удирдах ажилтнаас судалгаа авахад төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагад хангалттай үнэлгээ өгч байна. Ажил олгогчдын төлөөлөл Мөнхийн Тун, Еврофарм, Нахиа, Мон-Энтро зэрэг эмийн

үйлдвэр, ЭХНБ, эмийн сангийн эрхлэгч, гүйцэтгэх заирал, дарга нартай уулзалт хийж ярилцав. Ажил олгогчид тухайлбал; Алтанцэцэг /Мөнхийн Тун/, Тайванбат /Нахиа/ нар сургалтын агуулгыг өдгөө мөрдөгдөж буй хууль, тогтоол шийдвэртэй холбож өгөх асуудалд анхаарах, мэргэжлийн онцлогоо ухамсарлахад сургууль, багш нар анхаарч ажиллахыг зөвлөж байлаа.

Төгсөгчдийн төлөөлөл Мөнхийн Тун, МХЕГ, ЭМЯ, Монос-УБ, Цомбо эмийн үйлдвэр, Ховдын БОЭТ, Зэвсэгт Хүчний Клиникийн Төв Эмнэлэг, Ачтан эмнэлэг зэрэг улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байна. Ажил олгогчид болон төгсөгчдийн зүгээс суралцагчдад мэдлэг, чадвар олгохын зэрэгцээ хүн болж төлөвшихүүлэх ёстойг зөвлөж байна.

- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ зарцуулах дундаж хугацааг тогтоохын тулд АШУҮИС-н эм зүйн сургуулийг төгссөн төгсөгчдөөс санал асуулга авсан байна.

2014-2015 оны төгсөгчид ажилд ороход зарцуулагдсан хугацаа нь тэднээс өмнө төгссөн төгсөгчдөөс уртассан байна. Санал асуулгын дүнгээс харахад ажилд орохоор хүлээх хугацаа уртассан нь Эм зүйн мэргэжлээр бакалаврын боловсролтой мэргэжилтэн бэлтгэх хувийн хэвшлийн Их, дээд сургуулиуд олширсон, ажлын байранд тавигдах шаардлага өндөрссөнтэй холбоотой гэж үзсэн байна.

Төгсөөд ажилд орох хүртэлх хугацаа: 2011 онд-13 хоног, 2012 онд-10,5, 2013 онд-10,5, 2014 онд-9,7, 2015 онд-8 хоног байсан судалгаа байна.

Ажил олгогчид, төгсөгчид сургуульд сэтгэл ханамжтай байгаа хэдий ч төгсөгчдийн төлөвшил, ёс зүйн асуудалд анхаарах нь ихээхэн чухал байгааг онцолж байна.

Төгсөөд ажилд орох хүртэлх хугацаа харьцангуй богино байна.

Зөвлөмж:

1. Эм зүйчийн ёс зүй, харилцаа хандлагын хичээлийн агуулгыг боловсронгуй болгох, заах арга зүйг оновчтой тодорхойлох
2. Ажилд орох хугацааг богиносгох арга замыг судлах, ажлын байранд тавигдах шаардлагыг хангах оновчтой шийдлийн дагуу сургалтын агуулгыг боловсронгуй болгох

7.2 Хөтөлбөрийн үр нөлөө

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Эм зүйч мэргэжлээр төгсөгчид ажлын үр дүнгээ үнэлүүлэн, шагнагдаж, эрдмийнээр цолтой мэргэжилтнүүд жил бүр төрж байна.
- Эм зүйч мэргэжлээр төгсөгчид мэргэжлээрээ амжилттай ажиллаж эм зүйн салбарын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж байна.

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд

АШУҮИС-ын Эм зүйн сургуулийг төгссөн төгсөгчид төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж, ажлын үр дүнгээ үнэлүүлж байна. Тухайлбал төгсөгчидөөс Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан 11,2%, Эм зүйн ухааны магистр болон Эм зүйн ухааны доктор хамгаалсан хүн 6,93% байна.

- **Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь**

2011-2015 онд төгссөн 245 Эм зүйчдээс ЭХНБ-н захирал 3,4%, Эмийн үйлдвэрийн захирал 8,7%, 2 ба 3-р шатлалын эмнэлэгийн эмийн санд эрхлэгч дарга 19,01% байна.

- **Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/**

2011 оноос хойш төгссөн эм зүйчдийн 69,08% нь мэргэжлийн чиглэлээрээ ажиллаж байгаа бөгөөд Эрүүл мэндийн байгууллага иргэдэд зориулан “Эмийн зохистой хэрэглээ”, Эм зүйн салбарын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгүүдийг мэдээллэх сурталчиллах ажилд идэвхи санаачлагатай ажиллаж байна.

Эм зүйч мэргэжлээр төгсөгчид ажлын үр дүнгээ үнэлүүлэн, шагнагдаж, эрдмийнээр цолтой мэргэжилтнүүд жил бүр төрж байна.

Эм зүйч мэргэжлээр төгсөгчид мэргэжлээрээ амжилттай ажиллаж эм зүйн салбарын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж байна.

Зөвлөмж:

1. Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн холбоотой хамтран ажиллах үйл ажиллагааг тодорхой зорилтийн хүрээнд эрчимжүүлэх
2. Эм зүйн сургууль мэргэжлийн холбоо нийгэмлэгтэй хамтран “Эмийн зохистой хэрэглээ” ялангуяа “Антибиотикийн зохистой хэрэглээ” сэдвээр нийгэмд дорвитой шинэчлэл хийх ажлыг зохион байгуулах

7.3 Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Шинжээчийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Дүгнэлт:

- Төгсөлтийн өмнөх сургалтанд болон АШУҮИС-ийн дэргэд байгуулагдсан Олон улсын Сайбер Их сургуульд суралцаж буй гадаад оюутан хараахан байхгүй байна.
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь 3,75% байна.

- **Суралцаж буй гадаад оюутны тоо**

БНХАУ болон ОХУ-ын Эм зүйн тэнхимтэй багш оюутан солилцох арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна. 2014 оноос хойш БНХАУ-аас докторын сургалтанд 7 докторант суралцаж байна. Яг одоогийн байдлаар тус сургуульд гадаад оюутанд суралцаагүй байна.

- **Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт**

Тус сургууль нь Дэлхийн Анагаах Ухааны Боловсролын Холбоо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас санал болгож буй зарчмыг харгалзан үзэж эмнэлзүйд суурилсан Эм зүйчийн хөтөлбөрийг боловсруулж Эм зүйчийн ажлын байранд шаардагдах Мэдлэг Чадвар Хандлагын Цогц чадамжийг боловсруулан ашиглаж байна. Олон улсын Сайбер Их сургууль АШУҮИС-ийн дэргэд байгуулагдсанаар дэлхийн өнцөг булан бүрээс Эм зүйн шинжлэх ухааны хичээлүүдийг Онлайнгаар суралцах боломжтой болсон байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Эм зүйн сургуулийн 7 багш Англи-Монгол хэлээр 5 хичээлийн онлайн лекц бэлтгэн ашиглалтанд өгсөн байна.

- **Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт**

Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Нийт төгсөгчдийн 3,75% нь өндөр хөгжилтэй орнуудад мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцаж байна.

Төгсөлтийн өмнөх сургалтанд болон АШУҮИС-ийн дэргэд байгуулагдсан Олон улсын Сайбер Их сургуульд суралцаж буй гадаад оюутан хараахан байхгүй байна.

Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь 3,75% байна.

Зөвлөмж:

1. Эм зүйн сургуулийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд хүргэх, гадаад оюутан суралцах нөхцлийг хангах төлөвлөгөөг боловсруулан, үе шаттай хэрэгжүүлэх
2. Төгсөгчдийн чанар, чансаад үнэлгээ хийх, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эм зүйн сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

7.4 Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Эм зүйн мэргэжлийг суртачилах үйл ажиллагааг хийж байна.
- **Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал**
“Эм зүй”, “Эмийн мэдээлэл”, “Эм сэрэмж”, “Монголын эм зүй, эм судлал” зэрэг мэргэжлийн сэтгүүлүүдэд Эм зүйн сургалтын талаар мэдээлэл нийтлүүлсэн байна
- **Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа**
Суралцагчид, багш нар хамтран ажиллагч байгууллагуудад www.mnums.edu.mnсайтаар дамжуулан хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг хүргэж байна.
 - Эм зүйн мэргэжлийг суртачилах үйл ажиллагааг олон хэлбэрээр амжилттай хийж байна.

Зөвлөмж:

1. www.mnums.edu.mn сайтаар дамжуулан хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг зөвхөн мэргэжлийн байгууллага, хмүүст төдийгүй иргэд, их дээд сургуулиудад элсэгчдэд зориулсан онцлогт тохируулан боловсруулах, тогтмол, шинэлэг байдлаар түгээх

7-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ:

Шалгуур 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1 Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Шинжээчийн үнэлгээ:

АШУҮИС-ийн захирлын 2015 оны А/113 тоот тушаалаар Хөтөлбөрийн зөвлөл байгуулж, зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журмыг 2016 оны А/56 тоот тушаалын хавсралтаар батлан, мөрдөн ажиллаж байна.

АШУҮИС-ийн Сургалт бодлого зохицуулалтын газраас төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагаа, дадлага, сонгон суралцах хичээл явуулах журам, сургалтын технологи, чанарын хяналт хийх үлгэрчилсэн журам, оюутны мэдлэгийг үнэлэх журам зэрэг нэгдсэн бодлогоор хөтөлбөрийг чанартай явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Дүрэм журмыг тогтмол хугацаанд шинэчлэн сайжруулж, хэрэгжилтэд хяналт тавьж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон чанарын хяналт хийхэд :

- Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам /АШУҮИС-ийн захирлын 2015 оны А/144/
- Төгсөлтийн өмнөх үйл ажиллагааг зохицуулах журам /2015 он А/142/
- Дадлагын нэгдсэн журам / 2015 А/144 хавсралт №4/
- Сонгон суралцах хичээлийг зохион байгуулах журам /2015 А/144 хавсралт №2/
- АШУҮИС-ийн суралцагчийг үнэлэх журам /2015 А/144 хавсралт №1/

Энэ мөрдөж байгаа журам нь сургуулийн цахим хуудас болон Багшийн ажлын дэвтрийн хавсралт хэсэгт хэвлэгдсэн байгаа нь багш бүр байнга харж, мөрдөж хэрэгжүүлэх бололцоог бүрдүүлжээ. Сургалтын хөтөлбөрийг СБЗГазраас баталгаажуулсан загварын дагуу боловсруулсан байна.

Хөтөлбөрийн явцад хяналт тавих зорилгоор хөтөлбөрт оролцогч багш нарын хичээлд суун үнэлэх, тэмдэглэл хөтлөх, “Багшийн хичээлд суусан тэмдэглэл” хяналтын хуудастай байв. 2014-2016 оны хичээлийн жилд нийт 10 багш 1-3 удаа, нийт 20 удаа нээлттэй хичээл, явуулж, 6 профессор, дэд профессор багшийн хичээлд 7 багш, дадлагажигч багш нар нийт 30 гаруй удаа сууж, туршлага судалжээ. Сургалтын хөтөлбөрөөр суралцагсдын сэтгэл ханамжийн судалгаа г 2014, 2016 онуудад ижил асуумжаар хийсэн байна. 2014 онд 109, 2016 онд 77 оюутан хамрагджээ. Мөн суралцагсдаас сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд оюутны өөрсдийн оролцоог асуумж судалгаагаар тодорхойлсон байна. Хийсэн сэтгэл ханамжийн судалгааг харьцуулан дүгнэхэд 2016 оны судалгаанд оролцогсдын сэтгэл ханамж дээшилсэн байна.

Мөн 2013-2014 онд төгссөн нийт 68 төгсөгчөөс ЭЗ-н мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаанд сэтгэл ханамж ямар байгаа талаар асуумж судалгаа хийхэд онолын мэдлэг хангалттай 4.15, практик дадлага туршлага нь 3.38 гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь практик, дадлагын хичээлийн агуулгыг сайжруулах, чанаржуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Сургалтын хөтөлбөрийн чанарын гол үзүүлэлт нь үр дүн бөгөөд ЭЗС төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг шалгаж, 70%-иас дээш үнэлэгдсэн тохиолдолд эм зүйч мэргэжлээр төгссөн диплом олгодог байна. Төгсөгчдийн мэдлэгийг сорилын аргаар, мэдлэг болон чадвар, хандлагыг гардан шалгалт, өвчний тохиолдол шийдвэрлүүлэх аргаар шалгадаг байна. 2011-2016 оны эм зүйч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрөөр төгсөгчдийн шалгалтын дүнгийн судалгаанаас харахад дундаж нь:

- Онолын шалгалтын амжилт 100%, чанар 91,03%
- Дадлагын шалгалтын амжилт 100%, чанар 92,9% байна.

ЭМХТ-өөс олгодог эм барих эрхийн шалгалтаар АШУҮИС-ийн ЭЗС-ийг 2013-2015 онд төгссөн эм зүйчид 100% тусгай зөвшөөрлийн хөндлөнгийн шалгалтад тэнцсэн үр дүн харагдаж байна.

ЭЗС төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлагыг ажил олгогч нараас санал асуулгаар судалгаа хийсэн байна. Судалгаанд оролцсон ажил олгогч нарын 71,4% нь ЭЗС-ийн сургалтын чанарыг сайн% 7,1% нь маш сайн, харин 14,3% нь дунд зэрэг гэж үнэлсэн байна. Ажил олгогч нар төгсөгчдийн мэдлэгийг хангаттай, чадвар ба хандлагыг дундаж гэж үнэлсэн байна.

Шинээр ажилтан авахдаа төгссөн сургуулийг харгалзан үздэг эсэхийг ажил олгогчдоос тодруулахад 86% нь харгалзан үздэг байна. ЭЗС төгсөгчдийг ажилд авах сонирхолтой байдаг.

ЭЗС-ийн эмнэл зүйд суурилсан Эм зүйн сургалтын хөтөлбөр нь эм зүйч мэргэжилтэн бэлтгэх дэлхий нийтийн чиг хандлагад нийцэж байгаа, НЭМ-ийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэгдэж байгаа эсэхэд үнэлгээ өгч, цаашдын төлөвийг тодорхойлох хөтөлбөрт үнэлгээ хийх багийг 2014 онд томилж, судалгаа явуулсан байна. Энэ судалгааны дүнг хөтөлбөрийн чанарыг сайжруулах үндэслэл болгон, судалгааг үргэлжлүүлэн тогтмол хийж, дотоод хяналт, баталгаажуулалтад ашиглаж байна.

2014-2015 оны хичээлийн жилээс хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд Эм зүйн 2+3 хөтөлбөр болгон шинэчилж, ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн харьцааг 30:25:45 болгосон нь БСШУ-ы сайдын 2014 А/174 тоот тушаалын 2.2.1 заалтад нийцсэн байна. Шинэ хөтөлбөр нь уламжлалт хөтөлбөрөөс хэд хэдэн давуу талтай байна.

- Асуудлыг мэдээлэхээс шийдвэрлэх хэлбэрт шилжсэн
- Сургалтыг эмнэл зүйд ойртуулсан
- Оюутан төвтэй сургалтад шилжсэн
- Олон хичээл, салбарын мэдээллийг уялдуулсан
- Сурах арга барил эзэмшүүлсэн
- Багаар ажиллах чадварыг хөгжүүлсэн, харилцааны соёлд сургадаг.

2008 онд шинэчлэн батлагдсан эмнэл зүйд суурилсан Эм зүйн хөтөлбөрөөр 2013 онд 39 эм зүйч төгссөнөөс хойш 4 төгсөлт хийжээ. Эмнэл зүйд суурилсан сургалтын хөтөлбөрөөр суралцагсдаас өөрсдийн эзэмшсэн мэргэжлийн болон ерөнхий мэдлэг, чадварын түвшингээ хэрхэн үнэлж байгааг 35 төгсөгчөөс асуумж судалгаа авсан байна. Судалгаанаас үзэхэд өөрсдийн олж авсан мэдлэг, мэргэжилдээ сэтгэл ханамжтай байдаг байна.

Мэргэжилтний цогц чадамж боловсруулж, Эм зүйч хүний эзэмшвэл зохих 159 чадамжийг гаргасан байна. Энэхүү цогц чадамжид төгсөгчид, ажил олгогчдын Эм холбоо ТББ-ын саналыг тусгасан байна. Энэхүү мэргэжилтний цогц чадамж нь хөтөлбөрийг улам тодорхой зорилго, зорилттой, үр дүнг үнэлэх тодорхой шалгууртай болгож өгснөөрөө ОУ-ын ЭЗХ болон ОУ-ын Анагаахын Боловсролын холбооны хөтөлбөрийн чанарын хяналтад тавигдах шаардлагад нийцэж байна.

Чанарын үнэлгээ, баталгаажилтад SWOT шинжилгээ хийж, дүгнэсэн байна.

Дүгнэлт:

- **Эмнэл зүйд суурилсан Эм зүйн сургалтын хөтөлбөр нь Дэлхий нийтийн чиг хандлагад нийцсэн тусламж үзүүлэх чадвартай, ажил олгогчийн шаардлагад нийцсэн эм зүйч бэлтгэж байна.+Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 2+3 хөтөлбөр болгон шинэчилж, ерөнхий, мэргэжлийн, мэргэшүүлэх**

хичээлийн харьцааг 30:25:45 болгосон нь гадаадын зарим сургалтын хөтөлбөрийн агуулгатай ойртсон байна.

- Эм зүйн мэргэжлээр төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагын цогц чадамжийг боловсруулан баталснаар өөрийнхөө болон бусад эм зүйчийн түвшинг үнэлэх шалгууртай болсон байна.

- Чанарын үнэлгээ, баталгаажилтад SWOT шинжилгээ хийсэн бөгөөд сул тал, тохиолдож болох аюул заналыг тодорхойлж, авах арга хэмжээг төлөвлөсөн байна.

Зөвлөмж:

- Багш нарын ажлын ачааллыг багасгах,
- Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад багш нарыг мэргэшүүлэх, сургах
- Хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж өгөх

8-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эмзүйн сургуулийн “Эмзүй” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Г.Чойжамц/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Т.Алтанцэцэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../С.Аюурбуниа/

**Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эм зүйн сургууль “Эм зүй” сургалтын хөтөлбөр дээр ажиллах шинжээчдийн ажлын хуваарь
2017 оны 11 дүгээр сарын 21, 22**

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
2017-11- 21 Мягмар гараг		
09:00-10:30	Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна	Зохицуулагч
	Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ: - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	Шинжээчийн багийн ахлагч
	Сургуулийн захирал үг хэлнэ	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
	Удирдлага болон ӨҮ-гийн багтай уулзах: - Удирлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	Шинжээчийн багийн ахлагч
10:30-12:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана	Шинжээчид
12:00-13:00	Сургуультай танилцах аялал	Шинжээчид
13:00-14:00	Өдрийн хоол	
14:00-16:00	Оюутнуудтай хийх уулзалт	Шинжээчид
	Багш нартай хийх уулзалт	Шинжээчид
16:00-17:00	Шинжээчид номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана	Шинжээчид
17:00-18:00	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	Шинжээчид
2017-11-22 Лхагва гараг		
09:00-10:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	Шинжээчид
10:15-11:15	Төгсөгчидтэй хийх уулзалт	
11:30-12:30	Ажил олгогчидтой хийх уулзалт	
12:30-13:30	Өдрийн хоол	
13:30-14:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	
14:30-17:00	Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/	
17:00-18:00	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	

Оюутны төлөөлөл

№	Овог нэр	Цол	И-мэйл хаяг
1	Д.Энхжаргал	ЭЗУ-ны доктор, проф	enkjargal.d@mnums.edu.mn
2	С.Пүрэвсүрэн	ЭЗУ-ны доктор, дэд проф	purevsuren.@mnums.edu.mn
3	Х. Даариймаа	ЭЗУ-ны доктор, дэд проф	daariimaa@mnums.edu.mn
4	Ө.Энхбаатар	ЭЗУ-ны доктор	enkhbaatar.u@mnums.edu.mn
5	Ц.Ариунтуяа	ЭЗУ-ны магистр	ariuntuya.ts@mnums.edu.mn
6	Б.Даваадулам	ЭЗУ-ны магистр	davaadulam.b@mnums.edu.mn

Багш нарын төлөөлөл

№	Овог нэр	Анги хэсэг	Утасны дугаар	и- мэйл хаяг
1	Б.Загдаа	ЭЗ-303	80444416	zagdaa1997@gmail.com
2	А.Түвшинтогтох	ЭЗ-303	99671993	a_amgaa@yahoo.com
3	Н.Сүхтулга	ЭЗ-303	99403936	tulgaahi5@yahoo.com
4	Э.Билгүүн	ЭЗ-402	99754377	bilguunbegu55@gmail.com
5	Г.Лхагвасүрэн	ЭЗ-402	88080299	g.lhagvasuren95@gmail.com
6	М.Азбаяр	ЭЗ-408	99164689	Azkunya@yahoo.com
7	П. Алтанзул	ЭЗ-502	99279037	C_cherry43@yahoo.com
8	Р.Бишрэлт	ЭЗ-503	88998464	Bishrelt.1014@gmail.com
9	Э.Дашням	ЭЗ-504	86334447	dashimae@gmail.com
10	Ч.Батзул	ЭЗ-504	99390606	Batzul299@gmail.com
11	М.Март	ЭЗ-404	89671441	mart.munkhbat@yahoo.com

Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэр	Салбар	Ажлын газар	Албан тушаал
1	Г.Тайванбат	Эмийн үйлдвэр	Нахиа ХХК	Гүйцэтгэх захирал
2	Ц. Алтанцэцэг	Эмийн үйлдвэр	Мөнхийн тун ХХК	Гүйцэтгэх захирал
3	Р.Цогтуяа	ЭХНБ	Еврофарм ХХК	Гүйцэтгэх захирал
4	Оюунцэцэг	Эмийн сан	Маго фарм ХХК	Гүйцэтгэх захирал
5	Б.Оюун-Эрдэнэ	Эмийн сан	Мөнхийн тун ХХК	Эмийн сан хариуцсан захирал

Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэр	Төгссөн он	Ажлын газар	Албан тушаал
1	Э. Баасандорж	2011он	Энхийн шүүдэр ХХК	Чанарын баталгаажилтын менежер

2	Л.Ариунзаяа	2011 он	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэдэг	Клиник эм зүйч
3	Б.Мөнхзул	2011 он	МХЕГ-н ХАБУЛаборатори	Эм шинжээч
4	Э.Нямаасүрэн	2012 он	Монос ХХК	Аудитор
5	Ц. Цэрэнчимэд	2012 он	МХЕГ-н ХАБУЛаборатори	Эм шинжээч
6	Ц.Номин	2013 он	Ачтан эмнэлэг	Клиник эм зүйч
7	М.Долгион	2013 он	Говь эмийн сан	Эмийн сангийн эрхлэгч
8	М.Халиунаа	2014 он	ЭМЯ	Мэргэжилтэн
9	Д. Өлзийжаргал	2014 он	Мөнхийн тун ХХК	Эм зүйч менежер
10	Н.Гантулга	2015 он	Цэргийн төв эмнэлэг	Клиник эм зүйч
11	Т.Ууганбаяр	2015 он	Ховд аймаг БОЭТ	Клиник эм зүйч



АШУҮИС | ЭМ ЗҮЙН
СУРГУУЛЬ

14210 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо,
Ард Аюушийн гудамж, Шуудангийн хайрцаг - 48/111
Утас: 7018-0021

E-mail: Sop.group@mnums.edu.mn

2018.01.08 № 18/03

танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжийн тухай

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс томилогдсон шинжээчид Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эм зүйн сургуулийн "Эм Зүй" D091601 тоот бакалаврын сургалтын хөтөлбөрийг ахисан шатанд магадлан итгэмжлэхээр 2017 оны 11 сарын 21-22-ны өдрүүдэд тус сургууль дээр хуваарийн дагуу ажилласан.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс томилогдсон шинжээчид ажиллах хугацаандаа сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг 8 шалгуурын дагуу хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулийн сургалтын орчин, материаллаг нөөц, дадлагын лабораторитой биечлэн танилцаж оролцогч талын төлөөлөл багш, оюутан, төгсөгч, ажил олгогчидтой уулзаж, шалгуурын дагуу илрэл нотолгоотой нэг бүрчлэн танилцан багийн гишүүдтэй хамтран ажиллалаа.

БМИҮЗ-өөс ирүүлсэн шинжээчдийн өгсөн дүгнэлт зөвлөмж нь тус хөтөлбөрийн давуу тал, цаашид анхаарах зүйл, шалгуур түүний дэд бүлэг бүрт нарийвчлан зөвлөмж өгсөн нь бидний ажилд чухал дэмжлэг болохуйц гэж үзэн шинжээчдийн багийн дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрч байна.



ЗАХИРАЛ

Д. ДАВААДАГВА